# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2022 оны жилийн эцэс/

2023 оны 01 дүгээр сарын 18

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилгын 20 зорилтын 127 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газраас 2022 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 зорилгын 21 зорилтын 127 арга хэмжээний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг 91.15 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- Зорилго 1. /Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 12,467.5 тэрбум төгрөг байсныг 2022 онд 12,468.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2022 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2022 онд 836.4 мянган тоннд хүргэнэ/-д хамаарах 59 арга хэмжээний хэрэгжилт – 83.27%;
- ЗОРИЛГО 2. / Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2022 онд 85 хувьд хүргэнэ./-д хамаарах 9 арга хэмжээний хэрэгжилт – 95.56%;
- ЗОРИЛГО 3. / Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай

зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2022 онд 85 хувьд хүргэнэ./-д хамаарах 25 арга хэмжээний хэрэгжилт – 100%;

- ЗОРИЛГО 4. /Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2021 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна./-д хамаарах 7 арга хэмжээний хэрэгжилт – 95.71%;
- ЗОРИЛГО 5. /Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2022 онд 30 хоногт хүргэнэ./-д хамаарах 18 арга хэмжээний хэрэгжилт - 100.0%;
- ЗОРИЛГО 6. /Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2021 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 1.5 байсныг 2022 онд 1.3 болгон бууруулна./-д хамаарах 2 арга хэмжээний хэрэгжилт - 100.0%;
- ЗОРИЛГО 7. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд 5 үйлчилгээг нэгтгэнэ./-д хамаарах 7 арга хэмжээний хэрэгжилт - 87.14%-ийн тус тус биелэлттэй байна.

## ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2022 оны жилийн эцэс/

| Зорилго, зорилт | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | | | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | /-/ | |
| Зорилго 1. Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 12,467.5 тэрбум төгрөг байсныг 2022 онд 12,468.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2022 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2022 онд 836.4 мянган тоннд хүргэнэ. | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1 - ЗГҮАХ-3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ. ШСБ-ын 3.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна. | 17 | 9 | 3 | 3 | 0 | 1 | 0 | 1 | 88.13 |
| Зорилт 2 - ЗГҮАХ-3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. | 2 | 2 | 0 | | | | | | 100.00 |
| Зорилт 3 - ЗГҮАХ-3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | 8 | 7 | | | | | | 1 | 100.00 |
| Зорилт 4 - ЗГҮАХ-3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ. | 2 | | 1 | | 1 | | | | 70.00 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 5 - ЗГҮАХ-3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна. | 1 | 1 | | | | | | | 100.00 |
| Зорилт 6 - ЗГҮАХ-3.2.16. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно. | 5 | 4 | | | | | | 1 | 100.00 |
| Зорилт 7 - ЗГҮАХ-3.2.1. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. | 9 | | 1 | 2 | 2 | 3 | | 1 | 52.50 |
| Зорилт 8 - ЗГҮАХ-3.2.1.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | 15 | 4 | 3 | 7 | 1 | 0 | 0 | | 80.67 |
| Дүн | 59 | 27 | 8 | 12 | 4 | 4 | 0 | 4 | 83.27 |
| ЗОРИЛГО 2.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож ямны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2022 онд 85 хувьд хүргэнэ. | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1 - Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна. | 9 | 7 | 1 | 1 | | | | | 95.56 |
| Дүн | 9 | 7 | 1 | 1 | 0 | 0 | 0 | | 95.56 |
| ЗОРИЛГО 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2022 онд 85 хувьд хүргэнэ. | | | | | | | | | |
| Зорилт 1 - Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 3 | 3 | | | | | | | 100.00 |
| Зорилт 2 -Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | 18 | 17 | | | | | | 1 | 94.44 |
| Зорилт 3 - Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ. | 3 | 3 | | | | | | | 100.00 |
| Зорилт 4 - Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ. | 1 | 1 | | | | | | | 100.00 |
| Дүн | 25 | 24 | | | | | | 1 | 96.00 |
| ЗОРИЛГО 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2021 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна. | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1 - Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна. | 7 | 6 | 0 | 1 | | | | | 95.71 |
| Дүн | 7 | 6 | 0 | 1 | 0 | 0 | 0 | | 95.71 |
| ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2022 онд 30 хоногт хүргэнэ. | | | | | | | | | |
| Зорилт 1 - Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 6 | 6 | | | | | | | 100.00 |
| Зорилт 2 - Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно. | 3 | 3 | | | | | | | 100.00 |
| Зорилт 3 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын багцын төсвийн гүйцэтгэл 2021 онд 91,2 хувь байсныг 2022 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ. | 6 | 6 | | | | | | | 100 |
| Зорилт 4 - Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 3 | 3 | | | | | | | 100 |
| Дүн | 18 | 18 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО 6. Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2021 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 1.5 байсныг 2022 онд 1.3 болгон бууруулна. | | | | | | | | | |
| Зорилт 1 - Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийнэ. | 1 | 1 | | | | | | | 100 |
| Зорилт 2 - Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана. | 1 | 1 | | | | | | | 100 |
| Дүн | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | **100** |
| ЗОРИЛГО 7.Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд 5 үйлчилгээг нэгтгэнэ. | | | | | | | | | |
| Зорилт 1 - “Эрдэс баялгийн цахим засаглал” үндэсний арга хэмжээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | 7 | 4 | | 3 | | | | | 87.14 |
| Дүн | 7 | 4 | 0 | 3 | 0 | 0 | 0 | | 87.14 |
| **Нийт дүн** | **127** | **88** | **9** | **17** | **4** | **4** | **0** | **5** | **91.15** |

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 зорилгын 21 зорилтын 127 арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтийг **91.15** хувийн биелэлттэй гэж дүгнэв.
2. Нийт 127 арга хэмжээний биелэлтийг дүгнэсэн 88 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй, 9 арга хэмжээ нь 90 хувийн хэрэгжилттэй, 17 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, 4 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, 4 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй байна.

**Тав. Зөвлөмж**.

1. Зарим арга хэмжээг төлөвлөхдөө тухай онд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлж, нарийвчлан төлөвлөх
2. Биелэлт нь 50, 30 хувиар дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа дараах арга хэмжээг эрчимжүүлэх.
3. Хэрэгжээгүй арга хэмжээний талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх
4. Арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй болон дутуу биелэлт бичих, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах

Жич: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Батнайрамдал

# УУЛ УУРХАЙ,
# ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

## 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*Төлөвлөгөө хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД /Ж.ГАНБААТАР/
*(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /Б.БЯМБАДАГВА/
*(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ...................................

| Д/д | № | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024), УУХҮЯ-ны стратеги төлөвлөгөө (2020-2024). | Төсөв /сая.төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1. Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 12,467.5 тэрбум төгрөг байсныг 2022 онд 12,468.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2022 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2022 онд 836.4 мянган тоннд хүргэнэ.** | | | | | | | | |
| **1. ЗГҮАХ-3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.<br>ШСБ-ын 3.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.** | | | | | | | | |
| 1. | 1.1. | Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулах. | 1,232,006.2 /Гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээлээр/ | Далд уурхайн бүтээн байгуулалт, хувиар | Далд уурхайн бүтээн байгуулалт 78%. | Далд уурхайн бүтээн байгуулалт 80%-д хүргэнэ. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2022 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 73 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2022.12.01-ний байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-90%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-100%, далд уурхайн бүтээн байгуулалт 84%-д хүрсэн. Оюу толгойн уурхайд шаардлагатай бараа материалыг хил гаалиар саадгүй нэвтрүүлэх талаар холбогдох хүсэлтийг Хилийн боомтын зөвлөлд удаа дараа уламжлан ажиллаа. ЗГҮАХ-ийн хүрээнд “Оюу толгой” ХХК, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон “Эрдэнэс оюу толгой” ХХК-тай байнга холбогдож сар улирал тутамд мэдээлэл авч, холбогдох чиглэл өгч ажиллаж байна. | |
| 2. | 1.1.1 | Оюутолгойн төслийн далд уурхайг хэсэгчлэн ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг томилон ажилуулж, санал дүгнэлтийг гаргах. | - | Далд уурхайг хэсэгчлэн ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг томилон ажилуулж, санал дүгнэлтийг гаргасан эсэх, 0-Улсын комиссын санал, дүгнэлт гараагүй, 1-Улсын комиссын санал дүгнэлт гарсан | 0 | 1 | УУХҮСайдын 2022.05.19-ний өдрийн А/113 дугаар тушаалаар “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн бүтээн байгуулалттай газар дээр нь үзэж танилцаж, далд уурхайг ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Дээрх тушаалын дагуу УУХҮЯ, ЭХЯ, БОАЖЯ, МХЕГ, АМГТГ, ОБЕГ, Өмнөговь аймгийн засаг даргын тамгийн газар, “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс оюу толгой” ХХК-ийн төлөөлөл оролцсон комисс 2022.05.25-ны өдөр Оюу толгойн далд уурхайд ажиллаж, далд уурхайн бүтээн байгуулалт гүйцэтгэлтэй танилцаж, далд уурхайг хүлээж авах хүртэл, хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгсөн. Оюутолгой ХХК-иас Комиссын өгсөн зөвлөмж, даалгаварын хэрэгжилтийн тайланг ирүүлсний дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Оюутолгой” нэртэй зэс, алтны ордыг далд аргаар ашиглах уурхайн 2 дугаар үе шатыг ашиглалтад хүлээн авах тухай шийдвэрийг 2022.08.31-ний өдрийн 22/24 дугаар акт гарсан. | 100 |
| 3. | 1.1.2 | Оюутолгойн далд уурхайн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах. | - | Оюутолгойн далд уурхайн ТЭЗҮ-ийн тодотголд санал, дүгнэлт гаргах шинжээчдийн хэсгийн тушаалыг батлуулах 0-Батлуулаагүй 1-Батлуулсан. | 0 | 1 | Оюу толгой ХХК-иас Оюутолгойн далд уурхайн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг ирүүлээгүй байна. | /-/ |
| 4. | 1.2. | “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй | 322,939.3 | Ажлын явц, хувиар | Хүдрийн ил уурхайд | Хүдрийн ил уурхайд | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Монгол Улсын | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилт ээр 22.4%-ийг, зээлээр 77.6%-ийг/ | | мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 75%-д хүрсэн. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%-тай. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 73%-д хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ боловсруулах ажил 30%-д хүрсэн. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын нийт ажлын хэмжээнд гүйцэтгэл 69.4%-тай. | мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100%-д, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 100%-д, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 80%-д, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 70%-д хүргэнэ. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын нийт ажлын хэмжээнд гүйцэтгэл 75%-д хүргэнэ. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 45%-д хүрсэн. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%-тай болж буурсан байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хэлэлцүүлж хүлээн авсан. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 80%-тай байна.<br>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийн ажилд шаардлагатай бараа материал, үйлдвэрийн тасралтгүй ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын тээвэрлэлтийн ажлыг хил гаалиар саадгүй нэвтрүүлж өгнө үү гэсэн хүсэлтийг Хилийн боомтын зөвлөлд удаа дараа уламжлан ажилласан.<br>ЗГҮАХ-т хамрагдсан зорилтуудын хүрээнд ажлын гүйцэтгэл, тулгамдагдаж байгаа асуудлын талаар "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын холбогдох эрх бүхий албан тушаалтантай холбогдож сар, улирал тутам мэдээлэл авч ажилласан. | |
| 5. | 1.2.1. | Мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх. | 55,483.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилт аар 7.7%-ийг, зээлээр 92.3%-ийг/ | Ажлын явц, хувиар | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 75%-д хүрсэн. | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100%-д хүргэнэ. | Уурхайн тээвэрлэлтийн зай нэмэгдсэнээр олборлолтын зардал ихсэж байгаа тул олборлолтын өөрийн өртгийг бууруулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ хийгдсэн. /ТЭЗҮ ба Зураг төслийн ажлыг гэрээнд заагдсан графикийн дагуу хийгдэж байна. Барилга угсралтын талбайн түр барилга байгууламжийн ажлын явц бүрэн дууссан. Бутлуурын байгууламж, туузан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дамжуургын системийн геодези хэмжилтийн ажлыг эхлүүлэн трассыг чөлөөлөх ажил хийгдэж байгаа. Туузан дамжуургын трассын дагуу газар шороо, бэлтгэл ажил гүйцэтгэж байна. Метал хийц үйлдвэрлэлийн ажлын явц Бутлуурын байгууламж 100%, Туузан дамжуургын систем 100% дууссан. Нийт метал хийцийн тээвэрлэлтийн ажлын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц Бутлуурын байгууламж 90%, Туузан дамжуургын систем 85% байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 30%-ийн гүйцэтгэлтэй. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлтийн бодит гүйцэтгэл 45%-д хүрсэн гэж бууруулж үнэлсэн байна. Тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх гэрээний хугацаа дууссан. Гэрээг сунгах асуудал төсөвт өртөг нэмэгдсэнтэйгээр хойшлогдоод байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайн хөрс тээвэрлэлтийн өөрийн өртгийг 10 хүртэл хувиар бууруулах боломж бүрдэнэ. | |
| 6. | 1.2.2. | Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх. | - | Ажлын явц, хувиар | Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%-тай. | Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 100%-д хүргэнэ. | Тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадал 15000 тн болсноор Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тэсрэх бодисоор хангах боломж бүрдэнэ. Ил уурхайн өрөмдлөг, тэсэлгээний хэсэгт эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр барих ажлыг “Монголиан Инвестмент Корпорэйшн” ХХК 2020.05.08-ны өдөр 7/006-20 дугаартай “Ил уурхайн Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ” байгуулж ажил эхэлсэн. 2021.09.30-ны өдөр гэрээний хугацаа дууссан. 2022.12.31 хүртэл дахин сунгасан. 2023.02.28-нд ашиглалтад оруулахаар дахин төлөвлөсөн. “Эрдэнэт үйлдвэр” | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%-тай гэж бууруулж үнэлсэн бөгөөд 2023 онд багтаан ашиглалтад хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй үйлдвэрийн барилга байгууламжийн угсралтын ажил явагдаж байна. | |
| 7. | 1.2.3. | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх. | 239,003.5 /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилтээр 16.6%-ийг, зээлээр 83.4%-ийг/ | Ажлын явц, хувиар | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 73%-тай. | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 80%-д хүргэнэ. | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өргөтгөл шинэчлэлийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, овор ихтэй ачааг хил гаалиар нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор БНХАУ-ын талтай хэлэлцээр хийх асуудлаар ГХЯ, Эрээний гаалиар нэвтрүүлэх ачаа тээвэр, вагоны захиалгыг нэмэгдүүлэх талаар ЗТХЯ-нд албан бичгээр тухай бүр уламжилсан.<br>Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэх байгууламжийг шинээр байгуулах төслийн техник-эдийн засгийн үндэслэлд УУХҮСайдын 2022.02.21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар шинжээчдийн багийг томилон, 2022.05.09-ний өдрийн ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн батлуулсан.<br>2022.08.26-нд Баяжуулах үйлдвэрийн Өөрөө нунтаглах хэсгийн жилд 6 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4-р шугамыг ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгсөн. Уг шугамыг нэмж байгуулсанаар баяжмалын гарц 100 мянган тонноор нэмэгдэж, борлуулалтын орлого жилд 200 орчин сая доллараар өснө. Мөн 68 ажлын байр шинээр бий болж байна.<br>Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадлыг шат дараатай нэмэгдүүлэх өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд Өөрөө нунтаглах хэсэгт жилийн 6 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4-р шугамыг байгуулах ажил 2019-2022 онд хийгдэж, ашиглалтад ороод | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Уг шугам нь 2015 онд ашиглалтад орсон 3-р шугамтай тоног төхөөрөмж, технологийн хувьд мөн адил юм. 2022 оны 08 сард эхний 2 төслийн ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулсан. Үлдсэн 3 ажил тендер зарлах түвшинд хэрэгжиж байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 100% хүрсэн. | |
| 8. | 1.2.4. | Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх. | 28,452.8 /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилтээр 100%-ийг/ | Ажлын явц, хувиар | Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 39%-тай. | Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 70%-д хүргэнэ. | Төвийн болон Баруун бүсийн уул уурхай, аж үйлдвэрийн бусад салбарын импорт орлох металл бүтээгдэхүүний зарим хэрэгцээг хангах зорилтын хүрээнд цутгамал бүтээгдэхүүн, механик боловсруулалттай эд анги, барилгын болон үйлдвэрийн зориулалттай ган хийц, стандартын бус тоног төхөөрөмж, резинэн эдлэл, элэгдсэн эд ангийг сэргээн засварлах үйлдвэрлэлд түшиглэсэн уул уурхай, хүнд үйлдвэр, хөдөө аж ахуйн машин механизм, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн үйлдвэрлэлийг хөгжүүлж байна. Засвар, механикийн заводыг (2020-2024 он) үндэсний машин үйлдвэрийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төслийн ажлыг 2021.08.24-ний өдрийн 5/196-21 тоот гэрээний дагуу Ди Ди Эй Жи ХХК боловсруулж дууссан ба "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ажлын хэсэг хүлээн авсан. УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | 90 |
| 9. | 1.3. | Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах ажилд дэмжлэг үзүүлэх. | 1,166,564.8 /Өөрийн хөрөнгө, гадаадын хөнгөлөлттэй зээл/ | Ажлын явц, хувиар | Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Хөрөнгө | Бүтээн байгуулалтын ажил 93%-д хүргэнэ. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын | Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг өнгөрсөн онд ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Төсөл боловсруулагч хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-тай. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-д хүрсэн. | ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. | талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаварт тусгагдсан Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан.<br>Монгол Улсын засгийн газрын 2022.04.20-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлийн 1-д Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмж суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг УУХҮЯ, ХНХЯ-нд даалгасан. УУХҮСайд тус төслийн бүтээн байгуулалттай газар дээр нь очиж танилцсан.<br>Уул уурхайн салбарын нэн тэргүүнд хэрэгжүүлэх 10 том төслийн тоонд Цагаан суваргын зэс, молибдений төслийг хамруулж холбогдох судалгаа танилцуулга хийсэн. | |
| 10. | 1.4. | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжлэг үзүүлэх. | 1,484.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилт ээр 100%-ийг/ | Ажлын явц, хувиар | Шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 15%. | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 50%-д хүргэнэ. | 2022 оны байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн. БНХАУ-ын Гашуун сухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурсантай холбоотой “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул тус ажил нь тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15 (Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Туршилт судалгааны ажилд ирүүлсэн дээж нь ордыг төлөөлөхгүй | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна гэж дахин дээж авах ажлыг эхлүүлээд байна. Цаашид далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийхэд уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-ын чиглэлийн дагуу цуцлагдсан. Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д (О.Хуланд) даалгасан. УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/801 дугаар албан бичгээр ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх саналаа яаралтай танилцуулахыг үүрэг болгосон. УУХСайд Г.Ёндон, Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, АМГТГ-ын дарга Л.Баярмандал болон ҮГА-ын дарга О.Чулуунтай Асгатын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлаар 2022.05.23-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаас дараах арга хэмжээг авч ажиллахаар шийдвэрлэсэн. Үүнд:<br>-Асгатын ордод өмнө хийгдсэн геологи хайгуул, судалгааны тайлан болон техник, эдийн засгийн үндэслэлтэй танилцаж 2022, 2023 онуудад хийгдэх хайгуул судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах, тус хайгуулын ажлыг хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх талаар санал танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирлын үүргийг гүйцэтгэгч О.Хуланд; | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Хайгуулын ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг ҮГА, АМГТГ-т; -Асгатын ордын хүдэр тээвэрлэх зам гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явцын талаар “Эн Би Си Си” ХХК-тай уулзалт зохион байгуулж танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д тус тус даалгасан. Асгатын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эн Би Си Си” ХХК болон ЗТХЯ, УУХҮЯ-ны төлөөлөл оролцсон хурлыг 2022.07.06-ны өдөр зохион байгуулж, тус компаниас ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах төслийн ажлын явц, тулгамдаж буй асуудал болон холбогдох асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцсэн. Улмаар тус компаниас холбогдох асуудлаар үндэслэл бүхий тайлбар, тооцоо судалгаа, саналыг 2022.07.19-ны өдрийн 186 дугаар албан бичгээр хүлээн авч Эрдэнэс Монгол ХХК-нд уг асуудлыг судлан үзэж яаралтай хариу ирүүлэхийг даалгасан. “Эрдэнэс Монгол” ХХК-иас ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө ирүүлээгүй байна. | |
| 11. | 1.5. | Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах. | 640,188.0 /Төрийн өмчит компанийса нхүү-жилтээр/ | Ажлын явц, хувиар | Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс | Тавантолгой н нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд | Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 46.1%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 69.7%-д хүрсэн. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, ордыг иж бүрэн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 10%-тай. | нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 40%-д хүргэнэ. | ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, “Эрдэнэс-тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор технологийн харьцуулсан сонголт (1. олон утгуурт экскаватор-конвейер, 2. цахилгаан экскаватор-конвейер, 3. цахилгаан экскаватор-хүнд даацын автосамосвал) хийж,<br>өөрөө олборлогч компани болох, “Эрдэнэс-тавантолгой" ХК-ийн ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг далд уурхайн аргаар ашиглаж, экспортын хэмжээг нэмэгдүүлэх асуудлаар шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдэд хамруулж, холбогдох судалгаа танилцуулгыг бэлтгэн удирдлагдаа танилцуулж ажиллаа. | |
| 12. | 1.5.1 | Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг барих ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах. | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан эсэх.<br>0-Ажиллаагүй,<br>1-Ажилласан | 0 | 1 | Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх тухай Засгийн газрын тэмдэглэлийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.<br>Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий тендерийг 2021.08.13-ны өдөр зарласан бөгөөд тус тендер 2 удаа амжилтгүй болж улмаар 2022.02.17-ны өдөр дахин тендерийг зарлаж, 2022.03.02-ны өдөр нээн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Эрдэнэс Тавантолгой ХК-иас төслийн гүйцэтгэгчээр шалгарсан "Норинко Интернэшнл" XXK-тай 2022.04.14-ний өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн барилгын материалын татан авалтыг 2022 оны 10 дугаар сард хийж, суурь судалгааны ажлуудыг дуусгасан. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд анхдагч нүүрс хадгалах агуулахын суурийн цутгалтын ажил явагдаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 20%-тай байна. | |
| 13. | 1.5.2 | Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэлд санал, дүгнэлт өгч ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авах ажлыг гүйцэтгэх. | - | ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авсан эсэх<br>0-Хүлээн аваагүй,<br>1-Хүлээн авсан | 0 | 1 | Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төв байгуулах ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авсан. Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төвийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтын захиалга хийгдсэн бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажил 2022.04.22-ны өдөр эхэлсэн. Төслийн гүйцэтгэл 44.9%-тай байна. Төслийн ажлын зураг төслийг Өмнөговь аймгийн Ерөнхий архитектур болон холбогдох яам, тамгын газраар баталгаажуулах ажил хийгдэж байна. | 100 |
| 14. | 1.6. | “Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор технологийн харьцуулсан сонголт (1.олон утгуурт экскаватор-конвейер, 2.цахилгаан экскаватор-конвейер, 3.цахилгаан экскаватор-хүнд даацын автосамосвал) хийж, өөрөө олборлогч компани болох. | - | Технологийн харьцуулсан сонголтыг гүйцэтгэсэн эсэх<br>0-Гүйцэтгээгүй,<br>1-Гүйцэтгэсэн | 0 | 1 | Конвейерын системийн ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн инженерүүд, гадаадын болон үндэсний зөвлөх, инженерүүдтэй хамтран гүйцэтгэхээр 2022 оны төсөвт суулгаж ТУЗ-д танилцуулж батлуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэр дээр ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл авах ажлыг амжилттай зохион байгуулж улмаар гүйцэтгэх захирлын 2022 оны А/87 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан конвейерийн системийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна.<br>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгад яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022.06.08-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Эрдэнэс Тавантолгойн ил уурхайд конвейерийн системийг нэвтрүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, зөвлөх үйлчилгээг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн инженерүүд гүйцэтгэсэн. Улмаар УУХҮСайдын 2022.10.04-ний өдрийн А/249 дугаар тушаалаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсгийг томилсон. Шинжээчдийн хэсгээс урьдчилсан шүүмжийг нэгтгэн 2022.10.20-ны өдөр Эрдэнэс Тавантолгой ХК-д хүргүүлсэн. Шинжээчдийн шүүмжийг хүлээн авч холбогдох засварын ажлыг гүйцэтгэж байна. | |
| 15. | 1.6.1 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор технологийн харьцуулсан сонголтыг тус компанийн инженер техникийн ажилтнуудтай хамтран гүйцэтгэх. | 61,742.6 /Төрийн өмчит компанийн санхүүжилт ээр 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/ | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлтийн хувь | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэлт 7%-тай. | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 11%-д хүргэнэ. | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгад яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022.06.08-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17. | | | | | | | Эрдэнэс Тавантолгойн ил уурхайд конвейерийн системийг нэвтрүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, зөвлөх үйлчилгээг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн инженерүүд гүйцэтгэсэн. Улмаар УУХҮСайдын 2022.10.04-ний өдрийн А/249 дугаар тушаалаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсгийг байгуулсан. Шинжээчдийн хэсгээс урьдчилсан шүүмжийг нэгтгэн 2022.10.20-ны өдөр Эрдэнэс Тавантолгой ХК-д хүргүүлсэн. Шинжээчдийн шүүмжийг хүлээн авч холбогдох засварын ажлыг гүйцэтгэж байна. | |
| 16. | 1.6.2 | Ил уурхайн олборлолт хийх техник, тоног төхөөрөмж худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажилд хяналт тавьж ажиллах. | - | “Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолт хийх техник, тоног, төхөөрөмж худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажилд хяналт тавьж ажилласан эсэх,<br>0-Хяналт тавиагүй,<br>1-Хяналт тавьсан | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021 онд нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 5 хувьд хүргэхээр төлөвлөсөн. 2022 оны байдлаар уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7%-д хүрсэн. 130 тн даацтай автосамосвал 12 ш, 12 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2ш, 7-8 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2 ш, 13.7 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 10 м3 хутганы багтаамжтай дугуйт түрэгч 1ш, 8.5 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 4.3 м3 хутганы урттай автогрейдер 1 ш, тус бүр 20 м3 ёмкостой усны болон түлшний автоцистерн зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан байна. | 100 |
| 17. | 1.6.3 | “Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг далд уурхайн аргаар | - | Ил уурхайн аргаар ашиглах боломжгүй | 0 | 1 | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглах суурь судалгааны ажлыг эхлүүлэх. | | нөөцийг далд уурхайн аргаар ашиглах суурь судалгааны ажлыг эхлүүлсэн эсэх, 0-ажлыг эхлүүлээгүй, 1-ажлыг эхлүүлсэн | | | хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай “Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022.06.08-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор батлуулсан. | |
| **2.** | **ЗГҮАХ-3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 18. | 2.1. | Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах ажилд дэмжлэг үзүүлэх. | - | Ажлын явц, хувиар | Салхитын мөнгөний ордод түшиглэн байгуулагдах Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажил 80%-тай. | Салхитын мөнгөний ордод түшиглэн байгуулагдах Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, барилгын материалыг хилээр нэвтрүүлэх ажил 100%-д хүргэнэ. | Салхит уулын Баяжуулах 1 дүгээр үйлдвэр жилд 300 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд 2022 оны 05 дугаар сарын байдлаар 1,194.9 тонн баяжмал боловсруулан тасралтгүй ажиллаж байна. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бараа материал, тоног төхөөрөмжийн хомстол үүсч, татан авалт удааширсны улмаас Баяжуулах 2 дугаар үйлдвэр төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад оролгүй хойшилсон. 2022 оны 11-р сарын байдлаар 92.6 мян.тн хүдэр олборлож, 33.5 мян.тн хүдэр, 1.97 мян.тн баяжмал борлуулж, 45.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. ЗГҮАХ-т хамрагдсан зорилтуудын хүрээнд ажлын гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудлын талаар холбогдох эрх бүхий албан тушаалтантай холбогдож сар, улирал тутам мэдээлэл авч, хэлтэс, газрын дарга яамны удирлагуудад мэдээлэл танилцуулга бэлтгэн хүргүүлж ажиллаа. | 100 |
| 19. | 2.2. | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх. | - | Ажлын явц, хувиар | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад | 2021 оны эцэс, 2022 оны эхээр Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННҮ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна. Цахилгаан дамжуулах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оруулах ажил 10%-тай. | оруулах бэлтгэл ажлыг 100%-д хүргэж, хүдэр олборлолтын ажил эхэлнэ. | 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. 2022 оны хагас жилийн байдлаар налуу ам болон бусад малталтуудын хэмжээнд 485 м нэвтэрч 4673 м3 уулын цулын ажил гүйцэтгэсэн байна. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны далд уурхайн 2 налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1199.5 у.м нэвтэрч, /9894,7 м3 уулын цул нураасан уулын ажил хийж 78.9% гүйцэтгэлтэй байна. Уурхайн доод түвшин 1150 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмпийн барилга байгууламжийн ажил 85% гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 50 хувьд хүрсэн. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%. ЗГҮАХ-т хамрагдсан зорилтуудын хүрээнд ажлын гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудлын талаар холбогдох эрх бүхий албан тушаалтантай холбогдож сар, улирал тутам мэдээлэл авч ажилласан. | |
| **3.** | **ШСБ-3.1.2, ЗГҮАХ-3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 20. | 3.1. | 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулах. | Улсын төсөв 11,387.4 | Нутаг дэвсгэрийн 45%-ийг хамруулсан байна. | 41.97% | Нутаг дэвсгэрийн 45%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 18 талбай ялгана. | 1.Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50, Галбын говь-50, Бүрхтэй уул-50, Цайлангийн нуруу-50 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2022.05.31, 06.02, 06.15-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 29,381.83 км2 талбай буюу 1.88%, нийтдээ 43.86%-ийг тус судалгааны ажилд бүрэн хамруулаад байна. Эдгээр 7 төслийн судалгааны үр дүнд Мангирт (өнгөт металл P2 зэргээр Cu-2298.94 тн, мөнгө-7.248 тн, алт-2.352 кг, цайр-210 тн, хартугалга-315 тн), Эрдэнэ овоо (Алт шороо P1 зэргээр | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 65.5 кг), Хуурай сайр (P2 зэргээр алт-224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр алт-1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр алт-80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн), Далан шар уул (P3 зэргээр хром-526526 тн, никель-171515 тн), Дөш уулын төмөр зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг ялгасан.<br>2.2022 онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>•Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан.<br>•Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулсан.<br>•Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 нийт 6 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан.<br>•Хээрийн судалгааны ажилтай 4 төсөлд шуурхай хяналтыг ҮГА-тай хамтран 8-р сард хийсэн.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааныг 2022.03.17, 2022.04.13,14,15, 20-ны өдрийн хурлаар Халзан овоо-50, Хулд-50, Оорцог уул-50, Дөч гол-50, Өндөр ширээт-50, Хайрхан овоо-50, Ширээт уул-50, Алаг баян-50, Уушгийн улаан-50, Овоот толгой-50, Торлог уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Загал уул-50, Гилбэнт уул-50, Зангат уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Борзонгийн говь-50, Ямаат уул- | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 50, Буйлст хүрэн уул-50, Бөөн хөх уул-50, Хар хайрхан-50, Үнэгт уул-50, Улаангом-50, Их бэрх уул-50 төслүүдийг хэлэлцсэн.<br>•2022 оны төсөл, төсвийн тодотголын нийт 27 тэмдэглэл, 27 дүгнэлт батлагдсан.<br>•УТХ-2022-01 хурлаар хэлэлцсэн төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотголыг УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/98, 99, 100, 101, 105, 2022.05.13-ны өдрийн А/110 дугаар тушаалаар баталсан.<br>•ГЗЕЭА-ын зарим төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотголыг батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ны өдрийн А/187, 185, 184, 182, 181, 180, 170, 169, 168, 167, 166, 165, 164, 163, 162, 161, 160, 158, 157. 156, 155 дугаар тушаалаар тус тус баталсан.<br>•Их өлзийт-50, Түдэвтэй-50, Дэвийн хонгор уул-50, Модот толгой-50, Асгат уул-50 төслүүд (нутаг дэвсгэрийн 1.1%)-ийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | |
| 21. | 3.2. | 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15%-ийг хамруулах ажлын бэлтгэл ажлыг хангуулах. | - | Заавар, түүнд тавих шаардлагыг батлуулсан эсэх:<br>0-батлуулаагүй<br>1-батлуулсан | 0 | Заавар, шаардлагын төслийг хянаж, батлуулна. | Төрийн нарийн бичгийн даргын 2022.03.07-ны өдрийн 03/577 дугаар албан бичгээр 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаадлагын төслийг 2022 оны II улиралд багтаан ирүүлэх тухай албан бичгийг ҮГА-д хүргүүлсэн.<br>• Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн 2022-2023 оны санхүүгийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус зааврыг боловсруулах саналыг Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2022.04.08-ны өдрийн дотоод бичгээр хүргүүлсэн боловч дэмжигдээгүй.<br>•Үндэсний геологийн албаны дарга О.Чулуунаас 2022.07.26-ны өдрийн 1/421 дугаар албан бичгээр 1:25000-ны масштабын зураглалын ажлыг Улсын | /-/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх, заавры г боловсруулах нь эртэдсэн асуудал гэсэн хариуг ирүүлсэн. | |
| 47. | 8.1.2 | Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. | БХГ-ний дагуу тухайн жилд оруулах хөрөнгө оруулалтаар тодорхойлогдоно. /хувийн хэвшил/ | Шинээр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо. | Хайгуулын 23 БХГ | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. | Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд гэрээлэгчгүй байгаа 10 хайгуулын талбайд хийгдсэн хайгуулын ажлын жагсаалтыг гаргуулсан.<br>Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй газрын тосны хайгуулын “Хар Ус II” талбайд Ренова илч ХХК, “Номгон IX” талбайд Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК, “Дарьганга-XXIV” талбайд Монголиа шин ий энержи ХХК, “Хэрлэн тохой XXVIII” талбайд Хонгконг Вэлпэк Индастриал ХХК-тай тус тус байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны Засгийн газрын 337 дугаар тогтоол гарсан.<br>Газрын тосны хайгуулын Гурванбаян-XXX талбайд БХГ байгуулахаар Баян петролиум ХХК-тай хэлэлцээрээр тохиролцсон гэрээний төсөлд яамнуудаас санал авч байна. Одоогийн байдлаар 17 санал ирсэн бөгөөд ЭЗХЯ-аас санал ирүүлээгүй байна. Саналыг нэгтгэж дуусгаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | 70 |
| 48. | 8.1.3 | Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах. | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Нэмэгдсэн нөөцийн хэмжээ | Газрын тосны баталгаат нөөц 332 сая.тонн, ашиглалтын баталгаат нөөц 42 сая.тонн | Газрын тосны баталгаат нөөц 338.78 сая.тонн, ашиглалтын баталгаат нөөц 42.38 сая.тонн | Матад XX талбайн газрын тосны нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 10,2 сая тонн газрын тос олборлож, 9,8 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. Цаашид газрын тосны хайгуулын талбайнуудад | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 зэрэг талбайн мэдээллийг 2022.05.18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулсан.<br>Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн 2022.04.27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 25 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан. | |
| 49. | 8.1.4 | Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. | Ашиглалт, олборлолтын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтаар тодорхойлогдоно. /хувийн хэвшил/ | Газрын тосны олборлолтын тогтвортой байдал | Газрын тосны олборлолт 633.3 мян.тн | Газрын тосны олборлолт 834.3 мян.тн | Газрын тосны экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, хилийн боомтуудыг нээх тухай УУХҮСайдын 2022.04.08-ны өдрийн 1/935 дугаар албан бичгийг Улсын онцгой комисс болон Гадаад харилцааны сайд нарт хүргүүлсэн.<br>2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн Баянхошууны боомт ажиллаж эхэлсэн бөгөөд 2022 онд нийт 6.28 сая баррель буюу 851 мян.тн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2022.01.01-2022.12.07-ны байдлаар нийт 2 234 366 баррель буюу 302 817 тонн газрын тос олборлож, 2 288 431 баррель буюу 310 266 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна.<br>Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоол гарсан.<br>Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар Ерөнхий сайдын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар захирамжийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>Ажлын дэд хэсэг 4 удаа хуралдсан бөгөөд зарим гишүүд Дорнод аймгийн нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, мөн Тосон-Уул-XIX, Тамсаг-XXI талбайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалсан. Ажлын дэд хэсэг гэрээлэгч компанийн үйл ажиллагааг сайжруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх, газрын тосны салбарыг цаашид хөгжүүлэх талаар авах арга хэмжээ гэсэн чиглэлээр нэгдсэн санал, дүгнэлтээ боловсруулж Шадар сайд Засгийн газрын 2022.10.19-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас шуурхай авч хэрэгжүүлэх талаар Ажлын хэсэгт үүрэг чиглэл өгөөд байна.<br>Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тосны экспортын үйл ажиллагаа Баянхошуу хилийн боомт 2022.06.28-ны өдрөөс эхэлсэн бөгөөд Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл НҮТББ болон Нутгийн иргэдийн эсэргүүцлийн улмаас газрын тосны тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоох, зам талбайг хааж экспортын үйл ажиллагааг 10 хоног саатуулсан. Уг үйл ажиллагаатай | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбоотой асуудлаар УУХҮЯ, АМГТГ-аас холбогдох хүмүүс Тосон-уул-XIX, Тамсаг-XXI талбай дээр очиж жагсаал цуглаан зохион байгуулсан хүмүүс болон орон нутгийн удирдлагууд, Иргэдийн хурлын төлөөлөгч нар, Дорнод аймгийн цагдаагийн газартай хамтарсан уулзалтыг 2 удаа хийж ТББ-ын зүгээс тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх хугацаатай үүргийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д өгч газрын тосны экспортын тээвэрлэлтийг хэвийн үргэлжлүүлэх нөхцлийг хангаж ажилласан. 2022.09.21-ний өдөр УУХҮЯ, Ашигт малтмал газрын тосны газар, Петрочайна дачин тамсаг ХХК, Халхгол сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч, Матад сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч нартай хамтарсан хурал зохион байгуулж 2021, 2022 оны Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулсан. | |
| 50. | 8.2 | Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх. | /-/ Гадаад эх үүсвэр | Дамжуулах хоолойн зураг төсөл | Дамжуулах хоолойг санхүүжүүлж барих гүйцэтгэгчийг шалгаруулсан. | Дамжуулах хоолойн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн байна. | Дамжуулах хоолойн инженерчлэл, зураг төслийн ажил нь инженер, геологийн судалгааны, тосны шинж чанарын судалгааны, техникийн зураг төслийн, инженерчлэлийн ажлуудаас бүрдэж байна. 2022.12.10-ны өдрийн байдлаар инженер, геологи судалгааны ажил 100%, тосны шинж чанарын судалгааны ажил 100%, техникийн зураг төсөл (FEED)-ийн ажил 25%-ийн тус тус гүйцэтгэлтэй ба нийлбэр дүнгээр 39%-тай явагдаж байна. | 70 |
| 51. | 8.3 | Дамжуулах хоолой барих төслийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх. | /-/ Гадаад эх үүсвэр | Ажлын явц, хувиар | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан | Дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 10%. | Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилга угсралтын ажил 6 байршилд үргэлжилж барилгын ажил -40%, үйлчилгээний замын ажил -20%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, геодезийн судалгааны ажлын урьдчилсан тайланг бэлтгэж захиалагчид ирүүлсэн, Геотехникийн судалгааны ажил -90%, дээжлэлт шинжилгээ -90%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -70%, | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторит өгсөн тосны урсацын шинж чанрын шинжилгээний хариуг 2022.12.09-ний өдөр хүлээж авсан. Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажил -25%, БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННҮ тайлан -90% хийгдэж байна. | |
| 52. | 8.4 | Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих, газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах. | /БНЭУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээл/ | Ажлын явц, хувиар | Технологийн бус барилгын бүтээн байгуулалтын ажил /EPC-I/-ыг 36% байна. | Технологийн бус барилгын бүтээн байгуулалтын ажил /EPC-I/-ыг 100% дуусгаж, /EPC-II/, /EPC-III/-ын гүйцэтгэгчтэй гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн байна. Лицензит байгууламж /EPC-IV/-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25% | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-80,68%, Хоолны газар-89,82%, Лаборатори-89,17%, Эмнэлгийн барилга-83,84%, Агуулах-58,47%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-51,0%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Мега инженеринг инфраструкчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс текноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. | |
| 53. | 8.5 | Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. | /БНЭУ-ын 3Г-ын хөнгөлөлттэй зээл/ | Ажлын явц, хувиар | Технологийн бус барилгын бүтээн байгуулалтын ажил /EPC-I/-ыг 36% байна. | Технологийн бус барилгын бүтээн байгуулалтын ажил /EPC-I/-ыг 100% дуусгаж, /EPC-II/, /EPC-III/-ын гүйцэтгэгчтэй гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн байна. Лицензит байгууламж /EPC-IV/-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25% | Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд EPC-1-ийн барилга угсралтад шаардлагатай бараа материалыг импортлох, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх, төлбөрийн нэхэмжлэлийг баталгаажуулах хүсэлтийг нийт 79 удаа Сангийн яаманд, гадаад ажиллах хүчний асуудлаар ХНХЯ-нд, /EPC-2/, /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн тендерийн саналтай холбоотой үүсээд буй асуудлаар ГХЯ-нд, БНЭУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яам, БНЭУ-д суугаа элчин сайдын яам, БНХАУ-д суугаа элчин сайдын яам, ачаа тээвэрлэлтийн асуудлаар ЗТХЯ, Хилийн боомтын захиргаанд, төрийн өмчит компанийн зээлийн асуудлаар Хөгжлийн банкинд тухай бүр санал хүсэлтийг уламжилж шийдвэрлүүлж ажиллав. | 70 |
| 54. | 8.6 | Газрын тосны бүтээгдэхүүний чанарын стандарт, хяналтын | 2,834,500.0 Хувийн хэвшил | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн | 1.8 сая тонн | Шатахууны хангамж тогтвортой | Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нийт 203 аж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтолцоог сайжруулж, хангамжийг тогтворжуулах. | | тогтвортой байдал | | байна. Хэрэглээ 2.0 сая тоннд хүрнэ. | ахуйн нэгж улсын хэмжээнд шатахууны 89 агуулах, 1483 шатахуун түгээх станцаар дамжуулан газрын тосны бүтээгдэхүүний хангамж, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байна.<br>Монгол Улсын хэмжээнд 2022.12.12-ны өдрийн байдлаар нийт 1.7 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн бөгөөд үүнд ОХУ-аас 92.2%, БНХАУ 4.2%, бусад улсаас 3.6% импортлосон байна. Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор 2022 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 28 аж ахуйн нэгж 193,500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ нь тус аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, нөөцийн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.<br>Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, шатахуун худалдан авах урт хугацааны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хүрээнд ОХУ-ын Роснефть компанитай хийсэн 2 удаагийн уулзалт, хэлэлцээрийн үр дүнд 2022 оны 8 дугаар сараас дизель түлшний үнийг 5 хувь хямдруулж, 2023 оны 1 дүгээр сараас Аи 92 автобензинийг тонн тутамд 815 ам.доллароор, дизель түлшийг дэлхийн зах зээлийн үнээс 10 хувь хямдруулж авахаар тус тус тохиролцсон.<br>Импортын бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орших улсын хилийн зурвас газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулах барих зориулалтаар газар ашиглах” шийдвэр гарсан. Үүний дагуу | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | УУХҮСайдын 2022.04.05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын хилийн зурвאст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Гашуунсухайт болон Шивээхүрэнгийн боомтын шилжүүлэн ачих агуулахын байгууламжийн төслийг “Шунхлай групп” ХХК өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шалгарч, УУХҮЯ-тай хамтран ажиллах тухай 2022 оны №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэхүү төсөл хэрэгжиж, газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулах, байгууламж ашиглалтад орсноор уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй өрнөж буй өмнөд бүсийн шатахууны хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, жил бүр өсөн нэмэгдэж буй тус бүс нутгийн хэрэглээг тогтвортой хангах нөхцөл бүрдэх юм.<br>ОХУ-ын Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэрийн ээлжит засвар, үйлчилгээтэй холбоотойгоор 2022 оны 10 дугаар сард нийлүүлэлт удааширч Аи-92 автобензинийн нөөц багассан нөхцөл байдлын үед Роснефть Монголиа компани импортлогч аж ахуйн нэгжүүд болон УБТЗ-тай онцгой горимоор шуурхай хамтран ажилласны үр дүнд 10 дугаар сарын сүүлээр Аи-92 автобензинийн хангамж, нийлүүлэлт нэмэгдэж, нөөц хэвийн түвшинд хүрсэн. Мөн тодорхой гадаад хүчин зүйлийн улмаас 11 дүгээр сард дизель түлшний нийлүүлэлт удааширч, нөөц багассан нөхцөл байдлын үед Роснефть Монголия компани импортлогч аж ахуйн нэгжүүд УБТЗ-тай хамтран, дизель түлшний ачилт, тээвэрлэлт, татан авалт, буулгалтын ажлыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шуурхай зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.<br>2022.12.12-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 42, Аи-92 автобензин 34, Аи-95 автобензин 32, дизель түлш 16, ТС-1 онгоцны түлш 25 хоногийн нөөцтэй байна. | |
| 55. | 8.7 | Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | -<br>Хувийн хэвшил | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ, хувиар. | 15% | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 25%-д хүрсэн байна. | Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд Агаарын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 2020, 2021 онд Байгаль орчин, аялал жуулчлын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороонд тус тус хүргүүлсэн. 2022.04.22-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дах хэсэгт “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон. Ийнхүү Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлага хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн.<br>Монгол, Оросын иж бүрэн стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт “Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 2022 оны 24-р хуралдааны Протоколд болон ОХУ-ын “Роснефть” НХН болон Монголын шатахуун импортлогч компаниудын хооронд байгуулсан 2023 он хүртэл шатахуун нийлүүлэх урт хугацааны гэрээний дагуу шатахууныг тогтвортой нийлүүлэх, тэр дундаа К5 /Евро-5/ ангиллын шатахууны нийлүүлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх саналыг тусгасан. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл /3-р үе шат/-ийн хүрээнд УУХҮЯ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, АМГТГ, Япон улсын Жайка хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан Ажлын хэсэг ажиллаж байна. Уг төслийн хүрээнд Евро-5 /K5/ шатахууны хэрэглээг нэмэгдүүлэхэд импорт болон татварын бодлогын зохицуулалт нийт хэрэглэгчийн Евро-5 /K5/ хэрэглээний соёл нэвтрүүлэх, сурталчилан таниулах зэрэг ажлуудыг үе шаттай хамтран хэрэгжүүлэхээр Япон улсын Жайка хамтын ажиллагааны байгууллагын түлшний судалгааны мэргэжилтэнтэй 2022.12.07-ны өдөр уулзалт зохион байгуулсан.<br>Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулгыг УУХҮСайдын 2022.02.24-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн бөгөөд шатахууны гадаад үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан дизелийн түлшний Гаалийн албан татварыг “0” хувиар, НӨАТ-ыг “0” хувиар тогтоох асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.07.28-ны өдрийн 287 дугаар тогтоолын дагуу 2023 оны 1 дүгээр сарыг дуустал импортлосон дизель түлш дээр энгийн болон Евро5 ялгаваргүй онцгой албан татварыг “0” төгрөг болгон тус тус бууруулж шинэчлэн тогтоосон.<br>Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100 хувь импортоор хангаж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгаа бөгөөд 2022.12.12-ны бдрийн байдлаар нийт 1.7 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэнээс, 1.5 сая тонн шатахуун байна. Үүнээс Евро-5 /К5/ стандартын шаардлагад нийцсэн 346 мян.тонн шатахуун байгаа нь нийт импортолсон шатахууны 22,3 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 36 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2022 оны 12 дугаар сард БНХАУ-аас 20 мян.тн Евро-5 шатахуун авахаар захиалга хийгдсэн. | |
| 56. | 8.8 | “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын стандарт, хяналтын тогтолцоог сайжруулж, хангамжийг тогтворжуулах” ажлын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах. | - | Хяналт шалгалтын тоо | 1 | Жилд 1 удаа | Хүн амын нягтаршил ихтэй Улаанбаатар хотод газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн агуулахуудад төлөвлөлтийн үеийн галын аюулгүйн норм, техникийн ерөнхий шаардлага, стандартын дагуу үзлэг хийх удирдамжийг 2022.01.31-ний өдөр баталсан. Батлагдсан удирдамжийн дагуу 2022.03.10-наас 2022.04.30-ны өдрийн хооронд Улаанбаатар хотын 9 дүүрэгт газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагаа явуулж буй бүртгэлтэй 37 аж ахуйн нэгжийн 46 газрын тосны бүтээгдэхүүний агуулах, объектын байгууламжид агуулахын галын аюулгүйн норм, техникийн ерөнхий шаардлагын стандартаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалган, үзлэгт 100 хувь хамруулах ажлыг АМГТГ болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан.<br>Үзлэгт хамрагдсан дээрх аж ахуйн нэгжийн газрын тосны бүтээгдэхүүний агуулах, объектын газрын зориулалт, техник, тоног төхөөрөмжийн төлөвлөлт, байгууламжийн технологийн угсралт хийх эх загвар зураг батлахтай холбоотой галын аюулгүйн зай хэмжээний зөрчил үүсэх нөхцөлтэй байгааг стандартын шаардлагад нийцүүлэх зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах саналыг АМГТГ-аас 2022.11.22-ны өдрийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3/5670 дугаар албан бичгээр Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлсэн.<br>Газрын тосны бүтээгдэхүүний чанар стандартад хяналт тавих ажлын хүрээнд түлшний хүхрийн найрлагын судалгааг хэрэгжүүлж буй Жайка төсөл болон АМГТГ-тай хамтран Улаанбаатар хот дахь ШТС-иудад борлуулж буй дизель түлшнээс дээж авч, хүхрийн найрлагын хэмжилт хийх ажил АМГТГ-ын төв лабораторид сар бүр зохион байгуулагдаж байна.<br>2022.01.11-ний өдөр батлагдсан “Улаанбаатар хот дахь газрын тосны бүтээгдэхүүний чанар болон нөөцийн үлдэгдлийг хянах ажлын төлөвлөгөө”-ний дагуу Улаанбаатар хотын 6 дүүрэгт байрлах агуулах, шатахуун түгээх станцуудаас түүврийн аргаар нийт 287 дээж авч, чанарын хяналтын шинжилгээ хийх ажлыг АМГТГ, УУГТТЛ-той хамтран зохион байгуулсан. Шинжилгээний үр дүнгээр стандартын шаардлага хангаагүй үзүүлэлттэй гарсан 12 дизель түлшний дээжтэй холбогдуулан MNS 216:2017, MNS 217:2017, MNS 6861:2020 стандартуудын техникийн шаардлагад нийцсэн дизель түлш импортлох, борлуулахад анхаарч ажиллах чиглэлийг 2022.04.11-ний өдрийн 1/2140 дугаар албан бичгээр АМГТГ-аас нэр бүхий 11 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.<br>Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний чанар, хяналтын тогтолцоог сайжруулах, эрх зүйн орчин боловсронгуй болгох хүрээнд УУХҮЯ болон БНСУ-ын Газрын тосны чанар, хангамжийн газар (К-Петро) хооронд техник хамтын ажиллагааны санамж бичгийг 2022.08.10-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. Санамж бичгийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний чанар, хяналтын тогтолцоог сайжруулах, бодлого, эрх зүйн орчныг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бэхжүүлэх, БНСУ-ын газрын тос боловсруулах, газрын тосны химийн үйлдвэрлэлтэй холбоотой техник, технологийн туршлага судлах, сургалт зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. | |
| 57. | 8.9 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, бүрдүүлэлтэд хяналт тавих. | - | Компанийн нөөцийн хэмжээ | 120,350.00 тонн | Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоол 193,500.00 | Засгийн газрын 2012.11.10-ны өдрийн 126 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу жил бүр газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээ батлах тухай Засгийн газрын тогтоолыг батлуулдаг. Үүний дагуу Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор 2022 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 28 аж ахуйн нэгж 193,500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан.<br>Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 2022 оны 4 дүгээр сарын өртгөөр шинэчлэн тооцож, ГТБГ-ын Даргын 2022.03.31-ний өдрийн 08/814 дүгээр албан бичгээр, санхүүжилтэд хамрагдаагүй үлдсэн бусад аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулахад дэмжлэг хүсэх тухай УУХҮСайдын 2022.03.14-ний өдрийн 01/633 дугаар албан бичгийг Монголбанканд тус тус хүргүүлсэн.<br>Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд УУХҮСайдын 2022.02.01-ний өдрийн А/18 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх тухай гэрээний үлгэрчилсэн загварыг батлуулан ГТБГ-ын Даргын 2022.02.08-ны өдрийн 08/280 дугаар албан бичгээр АМГТГ-т хүргүүлсэн. АМГТГ-тай хамтран газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавин ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасны дагуу 2023 онд бүрдүүлэх компанийн нөөцийн бүтээгдэхүүний талаарх тогтоолын төсөл, танилцуулгыг УУХҮСайдын 2022.10.07-ны өдрийн 01/2648 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2022.10.19-ний өдрийн 378 дугаар тогтоолоор батлагдсан.<br>Засгийн газрын 160 тогтоолын дагуу өрийн баталгаа гаргах аргачлалаар нийт зээлийн 85%-ийг 10 аж ахуйн нэгжид олгосон. Мөн 2022 оны 4,5,6 саруудад АИ-92 шатахууны урьдчилгаа төлбөр хийх ажлыг Монголбанктай хамтран зохион байгуулсанаар АИ-92 шатахууны үнийн өсөлтөөс сэргийлсэн. | |
| 58. | 8.10 | Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах. | ТЭЗҮ-ээр тодорхойлогдоно. Хувийн хэвшил | Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ | 0% | БОНБНҮ-г боловсруулж, батлуулсан байна. 10% | Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0 га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад талд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийж байна. | 70 |
| 59. | 8.11 | Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулах. | - | Эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал | "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Эрчис ойл" ХХК, "Эрдэнэс Метан" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн | Газрын тосны судалгаа, шинжилгээ,хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл | Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өмчит компани байгуулах асуудлыг тусган оруулсан.<br>Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-нд батлагдсан, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил ААН-рүү шилжүүлэх бодлого барьж байгаа, мөн улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбогдуулан цаашид хэрэгжүүлэх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ачих байгууламж" ТӨҮГ | ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна. ГТБҮ-ийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу хийгдсэн байна. | боломжгүй байна. Одоогийн байдлаар төрийн өмчит ГТБҮ ТӨХХК, Эрчис ойл ХХК, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Эрдэнэс метан” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд чиг үүргийн дагуу газрын тосны үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.<br>Иймд Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулах асуудлыг ЗГҮАХ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс хасах саналыг ЗГ-т Хуулийн хэлтсээр дамжуулан хүргүүлсэн. | |
| **Зорилго 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгаа 2022 онд 85 хувьд хүргэнэ.** | | | | | | | | |
| **1.** | **Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна.** | | | | | | | |
| 60. | 1.1 | Геологийн салбарт баримтлах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх. | - | Үзэл баримтлалыг батлуулсан эсэх:<br>0-Батлуулаагүй<br>1-Батлуулсан | 0 | Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд үндэслэн хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан байна. | 1. Монгол Улсын Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу УУХҮСайдын 2021.04.06-ны өдрийн А/71 тушаалаар Газрын хэвлийн тухай хуулийн төслийг холбогдох судалгаа, тооцооны хамт Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.<br>“Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн (Амеп2) хүрээнд “Газрын хэвлийн тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлангийн төсөлд саналаа ТНБДаргын 2022.02.16-ны өдрийн 03/375 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>2. БШУСайдын 2022.06.17-ны өдрийн А/221 дугаар тушаалаар байгуудагдсан Цөмийн энергийн тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт УУХҮЯ-ны төлөөлөл ажиллаж байгаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бөгөөд хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.<br>3.“Монгол Улсын хилийн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг МУ-ын Их хурлын Байнгын хорооны 2022.11.16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан дэд ажлын хэсэг байгуулсан. Дэд ажлын хэсэгт УУХҮЯ-ыг төлөөлж ГБГ-ын албан хаагч ажиллаж байна. Тогтоолын үзэл баримтлал, анхан шатны хэлэлцүүлэг Байнгын хороо болон УИХ-ын чуулганаар тус тус хэлэлцэгдсэн. Эцсийн хэлэлцүүлэгт ороход бэлэн болсон. | |
| 61. | 1.2. | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдан гарах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барих. | - | УИХ-д өргөн барих ажлыг зохион байгуулах<br>0-зохион байгуулаагүй<br>1-зохион байгуулсан | 0 | 1 | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаран улсын уул уурхайтай холбоотой хууль тогтоомжийн судалгаа хийж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өөрчлөлттэй холбоотой санал, үзэл санааг сонсох, нэгдсэн нэг байр сууринд хүрэх зорилт тавин ажилласан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, тайланг хийгээд байна. Үүнд: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно. Мөн үзэл баримтлалын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас санал авахаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж, геологийн салбартай холбоотой оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг ажлын хэсэгт өгсөн.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг геологийн салбарын ТББ, аж ахуйн нэгж болон бусад холбогдох төлөөллүүдэд танилцуулж, санал авах уулзалтыг 2 удаа зохион байгуулсан. | |
| 62. | 1.3 | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барих. | 80,000000 | УИХ-д өргөн барих | Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байх | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулна. | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, тандан судалгааны ажлын тайланг хийж гүйцэтгэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021.09.27-ны өдөр цахимаар зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2022.02.01-ний өдөр өргөн мэдүүлэв. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох Ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Улсын Их хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт орж дэмжигдсэн бөгөөд 2022.12.14-ний өдрийн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-ын чуулганы эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдэхээр хүргүүлсэн бөгөөд УИХ-ын намрын ээлжит чуулганы 2022.12.23-ны өдөр хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдаад байна. | |
| 63. | 1.4 | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барих. | 80,000000 | УИХ-д өргөн барих | Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байх | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулна. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгааг хийн хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг Эдийн засаг, хөгжлийн сайдад 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичгүүдийг хүргүүлээд байна. | |
| 64. | 1.5 | Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барих. | | УИХ-д өргөн барих | Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байх | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулна. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагалдах хуулийн төсөл бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.11.22-ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн баталсантай холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл болон холбогдох бичиг баримтуудыг УУХҮСайдын 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65. | 1.6 | Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан эсэх:<br>0-үгүй<br>1-тийм | 0 | 1 | УИХ-ын даргын 2022.03.30-ны өдрийн 46 дугаар захирамжаар УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан бөгөөд УИХ-ын чуулганаар хэлэлцэхээр хүлээгдэж байна. УУХҮСайдаас Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэж батлсны дараа УИХ-аар хэлэлцүүлэх чиглэлийг 2022.11.22-ны өдөр өгөөд байна.<br>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулж, дагалдах 5 хуульд (Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай) нэмэлт өөрчлөлт оруулсан. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг, дагалдах хуулийн төслүүдийн хамт УИХ-ын 2022.07.05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд 2022.08.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. | 100 |
| 66. | 1.7 | Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулах. | - | ЗГ-т хүргүүлсэн эсэх<br>0-хүргүүлээгүй<br>1-хүргүүлсэн | Газрын тосны тухай хуулийн төсөл | 1 | УУХҮСайдын 2021.01.18-ны өдрийн А/12 дугаар тушаалаар газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсөлд санал авахаар яамны сайтад 2022.07.07-ны өдөр байршуулсан.<br>Хуулийн төсөл намрын чуулганы жагсаалтад ороогүй тул хүлээгдэж байна. | |
| 67. | 1.8 | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулах. | - | ЗГ-т хүргүүлсэн эсэх<br>0-хүргүүлээгүй<br>1-хүргүүлсэн | 2005 оны Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль | 1 | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын 2022.12.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлагдсан. “7.2.Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харъяалал, хяналтад байдаг нэгжээрээ агаарын хөлгийн түшнээс бусад бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно.<br>Зөвшөөрлийн тухай хууль 2022.06.17-ны өдөр батлагдсантай холбогдуулан “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж 2023.01.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлнэ. | 100 |
| 68. | 1.9 | Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын дүрэм, журам, заавар, норм норматив, стандарт, аргачлал, маягтыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах. | - | Боловсруулж, нэмэлт өөрчлөлт, оруулсан дүрэм, журам, заавар, норм норматив, стандартын тоо | 20 | 13 | **<u>ГБГ:</u>**<br>- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг шинэчилэн боловсруулж УУХҮСайдын 2022.05.02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2022.05.13-ны өдрийн 5828 дугаарт бүртгүүлсэн.<br>- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн боловсруулж УУХҮСайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2022.05.05-ны өдрийн 5821 дугаарт бүртгүүлсэн.<br>- Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг (берилли, никель-кобальт, фосфат, манган, хром) төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | УУХҮСайдын 2022 оны А/76 дугаар тушаалаар батлуулсан.<br>- “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” журамыг УУХҮСайдын 2022 оны А/275 дугаар тушаалаар батлуулсан. ХЗДХЯ-д 2022.10.31-ний өдрийн 03/2840 дугаар албан бичгээр хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.<br><br>**<u>УУБГ</u>**<br>1. “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг Засгийн газрын 2022 оны 164 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>2. Монголбанкны алт, валютын нөөцийг тогтвортой байлгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг 2022.03.23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан.<br>3. Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон үндсэн түүхий эдийг импортлох, экспортлоход улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх хилийн боомтын жагсаалт”-д нэр бүхий боомтуудыг нэмж оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн.<br>4. УУХҮСайдын 2021 оны А/297 тушаалаар байгуулагдсан “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2014” стандартыг шинэчлэн боловсруулах үүрэг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүхий Ажлын хэсэг нийт 5 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Стандартын шинэчилсэн төсөл аж ахуйн нэгжүүдээс санал авч төслийг 2022.06.10-ны өдрийн Уул уурхай, ашигт малтмалын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн, гишүүдийн 100%-ын саналаар дэмжигдэн, Стандарт, хэмжилзүйн газрын дарын 2022.07.04-ний өдрийн С28 дугаар тушаалаар батлагдсан.<br>5. “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг Засгийн газрын 2022 оны 164, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журам”-ыг 406 дугаар тогтоолоор батлуулсан.<br>6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой шинээр боловсруулсан болон шинэчлэн боловсруулсан стандартуудын төслүүдийн хэлэлцүүлэгт оролцож, стандартын төсөлд салбар хорооны гишүүдээс санал авч нэгтгэн, Стандарт хэмжилзүйн газарт хүргүүлсэн.<br>7. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журмыг шинэчлэн УУХҮСайдын 2022.12.12-ны өдрийн А/303 дугаар тушаалаар батлуулсан.<br>8. Засгийн газрын 2019.09.18-ны өдөр 355 дугаар, 2020.01.15-ны өдрийн 17 дугаар тогтоолуудтай холбогдуулан УУХҮСайдын 2020.11.09-ний өдрийн А/279 дугаар тушаалаар “Бичил уурхайн зохицуулалтын талаар” Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь журмын төслийг шинэчлэн УУХҮСайдын 2021.07.06-ны өдрийн 01/1739 дугаар албан бичгээр яамдуудаас санал авсан. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох шинэчилсэн журмын төсөлд яамдуудаас өгсөн саналыг дахин | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тусган санал авахаар яамдууд болон 21 аймгийн засаг дарга нарт УУХҮСайдын 2022.05.10-ны өдрийн 01/1360 дугаар албан бичгээр санал авахаар хүргүүлсэн. Яамдаас ирсэн саналыг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн 296 дугаар тогтоолын хавсралтаар "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журмыг шинэчлэн баталсан.<br><br>**<u>ХҮБГ:</u>**<br>-Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээ тогтоох аргачлалыг УУХҮСайд болон ХХААХҮСайдын хамтарсан тушаалаар 2022.06.22-нд батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5874 дугаарт бүртгүүлсэн.<br>-Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг УУХҮСайдын 2022.09.22-нд батлуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5959 дугаарт бүртгүүлсэн.<br>**<u>ГТБГ:</u>**<br>-"Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага" журмыг УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/288 дугаар тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6017 дугаарт бүртгүүлсэн.<br>-"Газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулж захиргааны хэм хэмжээнтий актын улсын нэгдсэн бүртгэлийн 6018 дугаарт бүртгүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журмын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, хууль тогтоомжийн дагуу хэлэлцүүлэг хийж, санал хүлээн авахаар төслийг яамны цахим хуудаст байршуулсан. Журмын төслийг эцэслэн боловсруулахаар ажиллаж байна. | |
| **Зорилго 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2020 онд 84.7 хувь байгааг 2022 онд 85 хувьд хүргэнэ.** | | | | | | | | |
| **1.** | **Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 69. | 1.1 | Валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг тогтворжуулах хүрээнд алтны үйлдвэрлэлд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. | - | УУХҮСайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А/102, А-177 тоот хамтарсан тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангасан эсэх 0-Хангаагүй, 1-Хангасан | 0 | 1 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020 оны А/102, А-177, 2021 оны А/52, А-82 дугаар хамтарсан тушаалд 2022.04.05-ны өдрийн А/62, А-97 дугаар хамтарсан тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хөнгөлөлттэй санхүүжилт олгох журмын 6.1-д заасны дагуу уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг хангасан алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох үйл ажиллагаа явагдаж байна.<br>Дээрх үйл ажилагааны хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монголбанкинд нийт 61 аж ахуйн нэгжийн жагсаалтыг хүргүүлсэн бөгөөд эхний ээлжинд БМНС ХХК, “Хаан булаг интернэйшнл” ХХК, Илт гоулд ХХК, “Вестерн ресурс” ХХК, “Хамтын эх булаг” ХХК, “Эс жи групп” ХХК, “Алтан гол эксплорэйшн” ХХК, “Алтай хангай бүрд” ХХК, “Наран мандал энтерпрайзес” ХХК, “Монрок” ХХК, “Хос хас” ХХК зэрэг нийт 13 ААН-д 52,095.45 сая төгрөгийн урьдчилгаа болон урт хугацааны санхүүжилтийг олгоод байна. | 100 |
| 70. | 1.2 | Нүүрсний үнэ, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд хийх нүүрсний тээврийг эхлүүлж, чингэлэгт | - | Тавантолгой-Гашуунсухайтын нүүрсний тээврийг эхлүүлсэн эсэх | 0 | 1 | Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 47 дугаар захирамжаар байгуулагдсан “Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тээврийн терминалын үйл ажиллагааг эрчимжүүлэх. | | 0-Зохион байгуулаагүй, 1-Зохион байгуулсан | | | даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, холбогдох мэдээлэл, саналыг тухай бүр өгч ажилласан.<br>Улмаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд хийх нүүрсний тээврийн үйл ажиллагаа 2022.05.25-ны өдрөөс эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд 2022.12.05-ны өдрийн байдлаар нийт 27.2 сая тонн нүүрс экспортод гаргасан байна. | |
| 71. | 1.3 | Хилийн Шивээхүрэн боомтод баригдаж байгаа чингэлэгт тээврийн терминалыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах. | - | Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан эсэх<br>0-үгүй<br>1-тийм | 0 | 1 | Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 47 дугаар захирамжаар байгуулагдсан “Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, холбогдох мэдээлэл, саналыг тухай бүр өгч ажилласан.<br>Улмаар хилийн Шивээхүрэн боомтоор хийх нүүрсний экспорт 2022.05.25-ны өдрөөс эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд 2022.12.05-ны өдрийн байдлаар нийт 27.2 сая тонн нүүрс экспортод гаргасан байна.<br>Хилийн Шивээхүрэн боомтод баригдаж байгаа чингэлэгт тээврийн терминалын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа, материалыг БНХАУ-ын талаас татан авах хүсэлтийг 2022.06.13-ны өдрийн 01/1681 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>Шивээхүрэн хилийн боомтын чингэлэгт тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг хойшлуулах “Албан татвар хэсэгчлэн төлүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022.09.05-ны өдрийн 335 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |
| **2. Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 72. | 2.1. | Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох асуудлыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх. | - | Асуудал шийдвэрлэгдсэн эсэх:<br>0- шийдвэрлэгдээгүй<br>1- шийдвэрлэгдсэн | 8 | Зарим ордын хил заагийг тогтоож Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. | УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын талбайн хил заагийг тогтоох бэлтгэл ажлыг гүйцэтгэж, талбайн хил заагийг тогтоон түүний газар зүйн солбицолыг тодорхойлсон хувилбарыг бэлтгэсэн. Гэвч Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Стратегийн ач холбогдол бүхий орд”-ын тодорхойлолт өөрчлөгдсөнтэй уялдан тухайн асуудлыг Засгийн газарт өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх асуудал тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Үүнтэй холбоотойгоор биелэлт гаргах боломжгүй байна. | /-/ |
| 73. | 2.2. | Төрөөс тогтоосон газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хил, заагийг тогтоох асуудлыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх. | - | Асуудал шийдвэрлэгдсэн эсэх:<br>0- шийдвэрлэгдээгүй<br>1- шийдвэрлэгдсэн | 0 | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. | 1.Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор баталсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хэмжээнд Үндэсний геологийн алба геологи-ашигт малтмалын шалгуур үзүүлэлтэд үндэслэн сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох 408 талбайг ялгаж тогтоосон.<br>2. Монгол Улсын Ерөнхий сайдад говийн аймгийн иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгох асуудал тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлсэн байна.<br>3. Дорноговь аймгийн Улаанбадрах суманд “Эрдэнэс Монгол” ХХК-д ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох асуудлаар материал бүрдүүлж, тогтоолын төслийг хүргүүлсэн ба ЗГ-ын 2022.03.09-ны өдрийн 110 дугаар тогтоолоор батлагдсан.<br>4. Орхон, Булган аймгийн нутагт орших Эрдэнэтийн зэс-молбденийн ордын хил заагт орших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй 99551.54 г ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох асуудлаар 2022.06.03-ны өдрийн 01/1593 дугаар албан бичгээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ХЗДХЯ-д тодруулга, тайлбар хүргүүлсэн. Тус асуудал нь 2022.10.19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэгдэн 379 дүгээр тогтоолоор баталгаажсан байна. | |
| 74. | 2.3. | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх бүх төрлийн геологийн судалгааны ажлын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, дүн шинжилгээ хийж тайлагнах. | - | Геологийн судалгааны ажлын хэрэгжилт<br>0- Хэрэгжүүлээгүй<br>1- Хэрэгжүүлсэн | 0 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн 60 төслийг хэрэгжүүлэн ажилласан байна. | •УУХҮСайдын 2022 оны төсвийн эх үүсвэрээр геологийн судалгааны ажлын 60 төслийг хэрэгжүүлэхээр УУХҮСайдын 2021 оны А/295 дугаар тушаалаар баталсан хэдий ч УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганаар МУ-ын 2022 оны төсөвт тодотгол хийж УУХҮСайдын төсвийн багцад батлагдсан санхүүжилтийг 5.2 тэрбум төгрөгөөр бууруулсантай холбоотойгоор 4 төслийг төлөвлөгөөт оноос хэрэгжүүлэх боломжгүй болсон тул хасч УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар 56 төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>•2022 онд хэрэгжих 56 төслөөс шинээр эхлэх 14 төслийн геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайдын 2022.01.10-ны өдрийн тушаалаар баталсан.<br>•Төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 42 төслийн 1-12 дугаар сарын ажлын гүйцэтгэл болон улирлын тайлан, хээрийн шуурхай хяналт, хээрийн анхдагч материалын хүлээн авсан нэгтгэл тайланг ҮГА-аас ирүүлсэнтэй танилцсан.<br>•Геологийн судалгааны төв ТӨҮГ, Минторес ХХК, Геомин ХХК, Гео эрэл зураглал ХХК, Геомин ХХК-аас ирүүлсэн төслийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах албан бичгүүдтэй танилцан хариуг холбогдох журмын дагуу ҮГА шийдвэрлэх болсныг мэдэгдсэн. 2022 онд үр дүнгийн тайлантай 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Хулд-50, Хайрхан овоо-50 төслийн суурин боловсруулалтын ажилд тайлангийн шуурхай хяналтыг хийсэн.<br>•Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын нутагт орших Ямбат уул-50, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Овоот шар-50, Увс аймгийн Сагил сумын нутагт орших Үүрэг нуур-50 төсөл, Увс аймгийн Өлгий сумын нутагт орших сэдэвчилсэн судалгааны ажлын ӨТТЭ-1 төсөлд хээрийн шуурхай хяналт хийх, төслийн хээрийн материал хүлээн авах асуудлаар томилолтоор 2022.08.29-09.13-ныг дуустал орон нутагт ажилласан.<br>Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын Үүрэг нуур-50, Торлог уул-50, Буйлст хүрэн уул-50, Цагаан-Овоо-50 төслүүдийн хээрийн материалыг хүлээн авах шуурхай хяналтаар 2022.11.18, 25-ны өдрүүдэд Үндэсний геологийн албатай хамтран ажилласан. | |
| 75. | 2.4 | Гадаад орон, Олон Улсын байгууллагуудтай геологийн салбарт хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрийн саналыг холбогдох газарт хүргүүлэх. | - | Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн эсэх:<br>0-Хэрэгжүүлээгүй<br>1-Хэрэгжүүлсэн | 0 | Харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | 1.Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн 2022-2023 оны санхүүгийн жилд хэрэгжих үйл ажиллагаанд Ашигт малтмалын ордыг цогц байдлаар судлан дагалдах бүрдвэрийн нөөцийг тооцоолоход мөрдөх аргачилсан зөвлөмжийн төсөл боловсруулах, 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг гүйцэтгэх заавар, түүнд тавих шаардлага боловсруулах, Орон нутаг, олон нийтэд зориулсан нөлөөллийн аян, контент үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа авах саналыг 2022.04.08-ны өдөр СХОГ-т хүргүүлсэн.<br>2.ХБНГУ-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээний төсөлд 2021 онд өгсөн саналын дагуу Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг гүйцэтгэгчээр ажиллах боломжтой салбарын эрдэмтэн, судлаачдын нэрсийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ГБГ-ын Даргын 2022.05.25-ны өдрийн 05/1509 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>3.БНСУ-ын Газар, тээврийн яамны буцалтгүй тусламжаар 2021-2024 онуудад Зүүн Азийн орнуудын төмөр замыг хөгжүүлэх, шинээр баригдах төмөр замын чиглэлүүдийн ачаа тээврийн эргэлт, ачааллыг тооцоолох төсөл хэрэгжинэ. Энэ хүрээнд БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн болон Монгол Улсын Үндэсний геологийн алба хооронд хамтран ажиллах гэрээ байгуулахтай холбогдуулан саналыг УУХҮСайдын 2022.05.16-ны өдрийн 01/1412 дугаар албан бичгээр ҮГА-д хүргүүлсэн.<br>4.Австрали Улсын Гадаад харилцааны яамтай хийх зөвлөлдөх уулзалтын ярианы сэдэв, АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдах “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын өдрүүд”, Канад Улсын Торонто хотноо зохион байгуулагдах PDAC буюу ОУ-ын уул уурхайн чуулга уулзалт, ИБУИНВУ-д зохион байгуулагдах хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын ярианы сэдэвт холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т 2022.01.17-нд хүргүүлсэн.<br>5.Геологи, ашигт малтмалын салбарт хамтран ажиллах тухай БНЭУ-ын Уул уурхайн яам болон МУ-ын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт холбогдох саналыг 2022.01.28-нд ГХАХ-т хүргүүлсэн.<br>6.Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ажлын хүрээнд гадаад улс, орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаар хийлгэх судалгаанд холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т 2022.02.09-нд хүргүүлсэн.<br>7.Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүнд үйлдвэрийн яам болон Бүгд найрамдах Чили Улсын Уул уурхайн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т 2022.02.21-нд хүргүүлсэн.<br>8.Гадаад харилцааны яам, Канад улсын Гадаад хэргийн яам хоорондын зөвлөлдөх уулзалтад холбогдох саналыг ГХАХ-т 2022.03.04-нд хүргүүлсэн.<br>9.Уул уурхайн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн Хамтын ажиллагааны хүрээнд холбогдох саналыг ГХАХ-т 2022.05.02-нд хүргүүлсэн.<br>10.Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Европ, гадаад хэргийн яам хоорондын зөвлөлдөх уулзалтын төлөвлөгөөний биелэлтийг ГХАХ-т 2022.05.10-нд хүргүүлсэн.<br>11.Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилтийн тайлан, УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдалын Канадын Ванкувер хотноо 2022.02.01-ний өдөр болох "Mining in Changing and Challenging Climate Conditions: Regional Trends, Innovations and Opportunities’’ сэдвээр болох цахим уулзалтынярианы сэдэвт тусгах геологийн салбарын мэдээлэл, төслийн саналыг ГХАХ-т, АНУ-аас хөрөнгө оруулах боломжтой Геологийн судалгааны төслтэй холбоотой саналыг бэлтгэн СХОГ-т хүргүүлсэн.<br>12.АНУ-ийн элчин сайдын яамны ахлах Д.Ричмондтой Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл сэдвээр уулзалт хийж харилцан санал солилцсон. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 13.Чехийн геологийн яамны төлөөлөлтэй 2022.10.13-нд уулзалт хийж 2 яам хоорондын харилцааг сайжруулах, ЗГ хоорондын санамж бичиг байгуулах талаарх санал солилцсон.<br>14.Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын 2022.11.11-ний өдрийн хуралдаанд оролцсон.<br>15.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хамтран ажиллах хэлэлцээрийн төсөл, Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлтэй тус тус танилцаж, холбогдох саналыг ГХАХ-т 2022.10.31-ний өдөр хүргүүлсэн.<br>16.Бүгд Найрамдах Солонгос Улс болон Монгол Улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, зам тээврийн хөгжлийн стратеги, ашигт малтмалын нөөц ба цаашдын чиг хандлага гэсэн сэдвийн дор 2022 оны 12 дугаар сард зохион байгуулсан хуралд УУХҮЯ-аас танилцуулах илтгэлийг бэлтгэсэн. | |
| 76. | 2.5 | Нутгийн өөрөө удирдах байгууллага, салбарын мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгжтэй хамтран орон нутагт бүсчилсэн уулзалтуудыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах. | | Уулзалт зохион байгуулсан эсэх:<br>0-Зохион байгуулаагүй<br>1-Зохион байгуулсан | 0 | Бүсчилсэн байдлаар 5 удаа зохион байгуулна. | Ашигт малтмал, газрын тосны газраас 2022.03.21-ний өдрөөс эхлэн Төр, хувийн хэвшил, орон нутгийн байгууллагын төлөөллүүд салбарт тулгамдсан асуудлыг нээлттэй ярилцаж, бүтээлчээр хэрэгжүүлэх зорилго бүхий “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдэл” уулзалт хэлэлцүүлгийг 18 аймагт зохион байгуулсан.<br>“Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хамтын ажиллагаа, боломж, шийдэл” Зүүн бүсийн хэлэлцүүлгийг салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ил тод, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Сүхбаатар аймагт зохион байгуулсан. /2022.03/<br>Монголын геологи, хайгуул-2022 арга хэмжээний үеэр Орхон, Булган, Өвөрхангай, Говь-Алтай, Дархан-уул, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудын Засаг дарга, орлогч дарга, холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтэн, улсын байцаагч гэсэн орон нутгийн нийт 18 төлөөллийг Улаанбаатар хотод урьж, “Засаг дарга нартай санал солилцох дугуй ширээний уулзалт”-ийг зохион байгуулсан.<br>Дорноговь аймгийн Мандах сум болон 2 дугаар багийн иргэдэд Геологийн салбар, геологийн судалгааны ажил, түүний онцлог, хэрэгжүүлэлтийг хангах хууль, тогтоомж зэрэг эрх зүйн байдал болон тухайн суманд гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн тухай уулзалтуудыг 2022.06.12-13-ний өдүүдэд Мандах сумын төвийн Соёлын төв болон 2 дугаар багийн Улаан шандад зохион байгуулсан. Уулзалтуудаар сумын иргэдийн асуултад хариулж, геологийн салбарыг сурталчилах ажлыг хийсэн. Мөн сумын Засаг дарга болон сумын захиргааны албан хаагчидттай уулаж, холбогдох мэдээллээр хангаж ажилласан.<br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ)-ийн Нарийн бичгийн даргын 2022.11.11-ний өдрийн А/17 дугаар захирамжаар Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших Халзан бүрэгтэй орд газрын үйл ажиллагаатай танилцан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж Ховд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагууд, Мянгад сумын ард иргэд, компаний төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 77. | 2.6 | Төрийн болон салбарын төрийн бус байгууллагуудтай хамтран чуулга уулзалт зохион байгуулж, хууль эрх зүйн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох. | | Чуулга уулзалт зохион байгуулсан эсэх:<br>0-Зохион байгуулаагүй<br>1-Зохион байгуулсан | 0 | 1 удаа зохион байгуулна. | Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Монголын геологи, хайгуул-2022” арга хэмжээг Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбоо, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, ШУА-ийн Палеонтологийн болон Геологийн хүрээлэн зэрэг байгууллагууд хамтран 2022.05.04,05-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо 12 дахь удаагийн чуулга уулзалтыг зохион байгуулсан.<br>Чуулга уулзалтад нийт 960 геологичид танхимаар, 6000 гаруй сонирхогчид дэлхийн өнцөг булан бүрээс цахимаар, Орхон, Булган, Өвөрхангай, Говь-Алтай, Дархан-уул, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудын Засаг дарга, орлогч дарга, холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтэн, улсын байцаагч гэсэн 18 төлөөлөл орон нутгаас биечлэн оролцсон. Тухайн арга хэмжээний үеэр зохион байгуулсан “Засаг дарга нартай санал солилцох дугуй ширээний уулзалт”-ийг зохион байгуулсан.<br><br>Монголын эдийн засгийн форум зохион байгуулах ажлын хүрээнд Аж үйлдвэржилтийн сэргэлт урьдчилсан хэлэлцүүлгийг зохион байгуулах Ажлын хэсэгт ажиллаж, 2022.03.24-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарах зөвлөмжийн төсөлд геологийн салбартай холбоотой асуудлыг тусгасан.<br><br>Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл, Монголын геологийн холбоо, Монголын геофизикчдийн холбооноос зохион байгуулсан мэргэшсэн болон зөвлөх олгох 3 удаагийн сургалтуудад Монголын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрөөс геологийн салбарт баримталж буй бодлого, хууль эрх зүйн орчины тухай нийт 6 цагийн сургалт хийсэн.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл болон бусад холбогдох ТББ-д танилцуулах санал авах уулзалтыг зохион байгуулсан.<br>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын хэлэлцүүлгийн 2022 оны 02, 03 саруудад тус тус зохион байгуулан танилцуулга хийсэн.<br>УУХҮСайдын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын танилцуулга анхаарах зүйлсийн талаарх сургалтыг Австрали-Монголын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕП-тай хамтран БлуСкай төвд зохион байгуулсан. Тус сургалтад 115 аж ахуйн нэгжийн 280 гаруй төлөөлөл оролцсон. Мөн уг сургалтыг 2022 онд цахим хэлбэрээр 3 удаа зохион байгуулсан.<br>Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбооны бүх гишүүд дэмжигчдийн V дугаар чуулганд Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал, түүний олголт, салбарын хууль эрх зүйн орчин чиглэлээр танилцуулга хийж 2022.12.09-ний өдөр ШУТИС дээр зохион байгуулсан.<br>НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй Хамтын Оролцоот Байгаль Орчны Мониторинг (ХОБОМ)-ын үр дүн, цаашид тогтвортой үргэлжлүүлэх эрх зүйн боломжийн талаар зөвлөлдөх талуудын уулзалт /Дорнод, Хэнтий, Дорноговь, Завхан аймгуудын төлөөлөгчид оролцсон /-д оролцсон. | |
| 78. | 2.7 | УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн болон хайгуулын ажлын | - | Зохион байгуулсан хурлын тоо: | 15 | 15 | УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн болон хайгуулын ажлын тайлан, нөөцийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тайлан, нөөцийн тооцоо хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах. | | | | | тооцоо хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулсан. Үүнд:<br>Улсын төсвийн хуралдаан 8 удаа<br>Хувийн хөрөнгийн хуралдаан 17 удаа<br>Өргөтгөсөн хуралдаан 2 удаа.<br>•Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 42 геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөний тодотголтой танилцан 2022.03.17-2022.03.25-нд ЭБМЗ-ийн улсын төсвийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн. Мөн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Чулуун хороот-50, Норовлин-50, Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Бүрхтэй уул-50, Галбын говь-50, Түдэвтэй-50, Цайлангийн нуруу-50, Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны УБ-геожкологи-2017 төслийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн 2022.05.29, 2022.06.03-ны хуралдаанд тус тус оролцож Чулуун хороот-50, Норовлин-50, Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50 төслүүдийн үр дүнг хүлээн авсан.<br>•Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын 64 тайланг хэлэлцэх 10 удаагийн ЭБМЗ-ийн салбар хуралдааныг зохион байгуулсан. | |
| | | УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн орд ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан хурлын тоо | 16 | 20 | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн өргөтгөсөн 5 удаагийн хуралдаанаар 11 техник, эдийн засгийн үндэслэл, 11 салбар хуралдаанаар 186 аж ахуйн нэгжийн 91 техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргасан. | 100 |
| | | УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан хурлын тоо | 5 | 5 | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааныг 6 удаа зохион байгуулж 15 төслийн ТЭЗҮ хэлэлцсэнээс 14 төслийн ТЭЗҮ-ийг хүлээж авахаар шийдвэрлэсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 79. | 2.8 | Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны зохион байгуулах | - | Зохион байгуулсан хурлын тоо | 0 | 8 | Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах болон бусад асуудлаар Мэргэжлийн зөвлөл 2022 оны эхний хагас жилд нийт 8 удаа хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргасан. | 100 |
| 80. | 2.9 | Уурхай, уулын болон баяжуулах 20 үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах. | - | Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авсан тоо | 0 | 10 | “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах түр заавар”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.02.08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан.<br>2022 онд Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Багануур ХК, Хуучин андууд ХХК, Монгойн гол ХК, Бэрх Уул ХК, Хавчигийн ам ХХК, Цээцээ импекс ХХК, Будар минералс ХХК, Мандах дорнын жонш ХХК, Жамц давс ХХК, Эрдэнэмайнинг үйлс ХХК, Тэвхэн ХХК, Айваору ХХК, Дамбат ХХК, Монгол базальт ХХК, Алтан дун дорнод Монгол ХХК, Уулс заамар ХХК, Монжин далай ХХК, Вестернресурс ХХК, Дэмси трейд ХХК, Алтан гол эксплорейшн ХХК, Меланж ХХК, Сэлэнгэ минералс ХХК, Хархорум сүлд ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Оюутолгой ХХК, Есөнхаш Эрдэнэ ХХК, Хан-Алтай ресурс ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Чамин алт ХХК, Хана интернейшнл ХХК, Идэр макс ХХК, Очир мандал хайрхан ХХК, Түмэн айл инвест ХХК, Стархолдинг ХХК-иудын нийт 34 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай нь газар дээр нь болон цахимаар танилцаж, холбогдох дүгнэлт гаргасан. | 100 |
| 81. | 2.10 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалтанд Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг | - | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны | 1780 га талбай | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн үйл | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн 2021 онд 2069,7 га-д техникийн нөхөн сэргээлт, 623.7 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.<br>Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу 2022 оны уулын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах. | | төлөвлөгөөнд тусгуулсан дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ | | ажиллагааны төлөвлөгөөнд дүйцүүлэх талбайгаар 2000 га талбайг нөхөн сэргээлт хийлгүүлсэн байна. | ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2 дугаар сард ирүүлнэ.<br>2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлт 507.7 га, биологийн нөхөн сэргээлт 306.2 га, пүйцүүлэх хамгаалах ажил 1388.8 га хийхээр төлөвлөсөн. Үүнд: Үүнд “Оюу толгой” ХХК Ялбаг орчмын 334.57 га, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 га талбайд нөхөн сэргээлтийн тендер зарлагдаж сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. Нийслэлийн ЗДТГ-аас Налайх дүүргийн 3-р хороонд нүүрсний олборлолтын улмаас эвдрэлд орсон 40 га газрын нөхөн сэргээх ажлын тендер зарласан. | |
| 82. | 2.11 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигаар батлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийг мод тарих үйл ажиллагаанд татан оролцуулах, хэрэгжилтийг хангах. | - | Холбогдох төлөвлөгөө, дүрэм, журмыг боловсруулсан эсэх<br>0- Боловсруулаагүй<br>1- Боловсруулсан | 0 | 1 | “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлах арга хэмжээний түр журмын төслийг боловсруулан УУХҮСайдын 2021.11.30-ны өдрийн 01/2958 дугаар албан бичгээр БОАЖЯ-нд санал авахаар хүргүүлсэн.<br>БОАЖСайдын 2022.01.28-ны 01/523 дугаар албан бичгээр хамтран батлах эрхийг хуулиар олгосон заалт байхгүй тул хамтарсан журмын төслийг дэмжээгүй санал ирүүлсэн. | 100 |
| 83. | 2.12 | Жоншны салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | - | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн эсэх<br>0 - Хэрэгжүүлээгүй<br>1- Хэрэгжүүлсэн | 0 | 1 | Хайлуур жоншны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 128 аж ахуй нэгжүүдийн нөөцийн хөдөлгөөн болон олборлолтод үнэлэлт дүгнэлт өгч, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль, дүрэм, журмыг зөрчин ажиллаж байсан аж ахуйн нэгжүүдэд холбогдох арга хэмжээ авах саналыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Экологийн цагдаагийн албанд хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Мөн УУХҮСайдын 2022.06.10-ны өдрийн А/128 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2022.06.25-28-ны өдрүүдэд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дундговь аймгийн Баянжаргалан сум, Говьсүмбэр аймгийн Шивээговь сум, Дорноговь аймгийн Даланжаргалан сум, Айраг сум, Мандах сум, Хатанбулаг сум, Өмнөговь аймгийн Номгон сум, Хүрмэн сумын нутагт олгогдсон зарим ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн талбайд ажиллаж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал, дүгнэлтийг гаргаж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар тогтов. | |
| 84. | 2.13 | Газрын тосны хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах ажлыг зохион байгуулах. | - | Нээлттэй сонгон шалгаруулалт зарласан талбайн тоо | 0 | 1 | Газрын тосны хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлахтай холбогдуулан Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-т заасны дагуу аймгуудын ИТХ-аар хэлэлцүүлж, тогтоол гаргуулсан. Тус тогтоолуудыг үндэслэн газрын тосны хайгуулын Номгон IX, Төхөм X хойд, Цагаан Элс XIII, Зүүнбаян XIV, Дарьганга XXIV талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай УУХҮСайдын 2022 оны А/294 дугаар тушаал гарсан. Тушаалыг АМГТГ-т хүргүүлсэн. | 100 |
| 85. | 2.14 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих. | - | Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн 311 дугаар тогтоол | 120350 тонн | 193500 тонн | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасны дагуу “Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2022 онд бүрдүүлэх компанийн нөөц”-ийн тогтоолын төсөл, танилцуулгыг нэгтгэн Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор нэр бүхий 28 аж ахуйн нэгжид 45 хоногийн хэрэглээний буюу 193500 тн (А-80-7500тн, АИ-92-60000тн, ДТ-123000 тн, ТС-1 3000 тн) шатахуун бүрдүүлэхийг даалгасан. 2022.12.12-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар А-80 автобензин 40 хоног, Аи-92 автобензин 37 хоног, Аи-95 автобензин 31 хоног, дизель түлш 16 хоног, ТС-1 онгоцны түлш 27 хоногийн ердийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна.<br>Нөөц бүрдүүлэлтэд АМГТГ-тай хамтран тухай бүр хяналт тавин ажиллаж байна. | |
| 86. | 2.15 | Газрын тосны салбар үүсч хөгжсөний 81 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах. | - | Хэрэгжилт % | 0% | 100% | Газрын тосны салбар үүсэж хөгжсөний 80, 81 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллан, 2022.05.27-ны өдөр амжилттай зохион байгуулсан. | 100 |
| 87. | 2.16 | Гадаргын усыг ашиглах төсөл хэрэгжих хүртэлх хугацаанд Таван толгойн нүүрсний ордыг түшиглэн байгуулах үйлдвэрүүдийн ус хангамжийг газрын доорх усаар хангах ажлыг зохион байгуулах. | 120,766.8 сая.төг | Бүтээн байгуулалтын ажлын явц хувиар | 0% | 60% | -Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.01.11-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврын хүрээнд “Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарыг тодорхойлж Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр болон кокс, эрчим хүчний үйлдвэрт шаардлагатай ус хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг (presentation) 2022.01.26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж Засгийн газрын 06 дугаар тэмдэглэл гарсан.<br>Тавантолгойн нүүрсний бүлэг ордуудыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх тухай албан хүсэлтийг холбогдох судалгаа мэдээллийг УУХҮСайдын 2022.04.26-ны өдрийн 01/1186 дугаар албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн бөгөөд ЗГХА Усны газрын 2022.05.18-ны өдрийн 01/581 дугаар албан бичгээр Тавантолгойн дулааны цахилгаан станц болон Нүүрс баяжуулах үйлдвэр төслүүдийн ус хангамжийн эх үүсвэрийг Дорноговь аймгийн Мандах сумын Цагаан цавын газрын доорх усны ордоос хангахаар шийдвэрлэсэн.<br>-Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах ус хангамжийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах “Загийн усны хоолой”-н газрын доорх усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг Барилгын хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.12.15-ны өдрийн байдлаар 69.7 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 88. | 2.17 | Технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журмын хэрэгжилтийг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | -Технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журмын 2.1 дэх хэсэгт заасны дагуу Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.01.13-ны өдрийн А-06/А-05 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан.<br>-Технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох ажлын хүрээнд технологийн түвшний үнэлгээ хийх эрх авах хүсэлт ирүүлэх тухай зарлал, мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд 2022.04.14-ний өдөр байршуулж, ирүүлсэн хүсэлтийг орон тооны бус Зөвлөлийн 2022.06.21-ний өдрийн хурлаар хэлэлцэж, Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/381/А/274/А-313 дугаар хамтарсан тушаалаар баталсан. “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ын 3.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/281, А/210 дугаар хамтарсан тушаалаар “Эрдэнэс үндэсний судалгаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжлийн төв" ХХК-д хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг 3 жилийн хугацаатай олгосон. | |
| 89. | 2.18 | "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах" төслийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах. | - | Танилцуулсан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | 1.Монгол Улсын Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу "аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулж" Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2022.05.24-ний өдрийн 01/1500 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>2.Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.01.11-ний өдрийн 01 дугаар "Албан даалгавар"-аар даалгасны дагуу "Эрдэнэт, Оюутолгой зэрэг ордыг иж бүрэн ашиглаж, зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүдийн талаар" Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2022.06.03-ны өдрийн 01/1590 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>3."Аж үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркуудыг барих төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар" Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2022.06.03-ны өдрийн 01/1591 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| **3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.** | | | | | | | | |
| 90. | 3.1 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэх. | - | Олгосон тусгай зөвшөөрлийн тоо | 2021 онд 34 | 20 | Могойн гол ХК, Илчит металл ХХК, Редпаф Монгол ХХК, Спейшл майнинг сервис ХХК, Их оч ХХК, Цемент шохой ТӨХК, Мера сервис ХХК, Талст бластинг консалтинг ХХК, Бласт мануфактуринг групп ХХК, Мөнхтэтгэгч хүч ХХК, Майн тех бластинг ХХК, Монполимет ХХК, Кемекс ХХК, Апа менежмент ХХК, Оюутолгой ХХК, Монполимет ХХК, Кемекс ХХК, Үнэн анд ХХК, Апа менежмент ХХК-ийн тусгай зөвшөөрлийг сунгасан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Их гүрэн инвестмент ХХК, Мегатон энержи ХХК, Их эрхэт даймонд ХХК, Би Ти девелопмент ХХК, Дрийм АГЭ бласт ХХК, Мастер майнинг сервис ХХК, Баянтээг ХК, Эн Ар Жи ийрт воркс ХХК, Хартарвагатай ХК, Мера инженеринг ХХК-д тусгай зөвшөөрөл олгосон.<br>2022 онд сунгасан 20, шинээр 10 нийт 30 аж ахуйн нэгжид тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай олгож, сунгасан. | |
| 91. | 3.2 | Хүнд үйлдвэрийн салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэх. | - | Олгосон тусгай зөвшөөрлийн тоо | 2021 онд 18 | 2022 онд 2021 оны түвшинд хадгална. | Хүнд үйлдвэрийн салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэх ажлын хүрээнд Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх, Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг тусгай зөвшөөрлийн цахим систем https://license.mn/-ээр дамжуулан авах ажлыг Сангийн яамны Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран туршилт судалгаа хийж, 2022.08.01-ний өдрөөс эхлэн хүлээн авч олгох, сунгах, хүчингүй болгох, цуцлах зохицуулалтыг хийж байна.<br>2022 оны байдлаар “Эрдэнэт сэтгэмж” ХХК, “Жараахайн булаг” ХХК, “Мөнгөн полимер” ХХК, “Сэйф рийч” ХХК, “Батмонгол хийц” ХХК, “Улаанбаатар БҮК” ХХК, “Зонхалиун соронз” ХХК, “Монгол 8888” ХХК, “Электрокем” ХХК, “Зэвсэгт хүчний 011 дүгээр анги” УТҮГ, “Наран төмөр” ХХК, “Гэрэлт оньс” ХХК, “Ораметалл” ХХК, “Эрдэм гоёл” ХХК, “Эс энд Эм сольюшн” ХХК, “Үлэмж хүдэр” ХХК, “Талст урлан” ХХК, “Корзин металл материалс” ХХК, “Мөнх гэрэлт оргил” ХХК, “Талын металл нунтаг” ХХК, “Кэй Эйч интернэшнл” ХХК, “Хан оч марал” ХХК, “Баян өргөө хишиг” ХХК, “Бэрэн металл”ХХК зэрэг нийт 24 ААН-ээс | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан бичгээр болон цахим системээр хүсэлт ирүүлснээс 20 ААН-д тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олголт, сунгалтыг хийж, 4 ААН-ийн хүсэлтийг буцааж, цуцалсан байна. Үүнд: Шинээр олгосон-9, сунгалт хийсэн-11, цуцалсан-1, буцаасан-3. | |
| 92. | 3.3 | Газрын тосны салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэх. | - | Олгосон тусгай зөвшөөрлийн тоо | 2021 онд 121 | 2022 онд 2021 оны түвшинд хадгална. | Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн бүх төрлийн шатахуун болон шатдаг хий импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг УУХҮСайдын 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-д нийцүүлэн хянаж, шуурхай шийдвэрлэж байна. Бүх төрлийн шатахуун, шатдаг хийн худалдааны чиглэлээр олгосон нийт 203 ААН-ийн 364 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Үүнээс бүх төрлийн шатахуун импортлох 92, бөөний худалдаа эрхлэх 96, жижиглэнгийн худалдаа эрхлэх 114, шатдаг хийн импортлох 17, шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх 19, АХЦС-аар худалдах 18, баллоноор худалдах 8 байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 1 дүгээр албан даалгавраар өгсөн үүргийн дагуу бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2022 оны 3 дугаар сараас зөвхөн https://license.mn/ цахим хуудсаар дамжуулан 100 хувь цахимаар хүлээн авч тухай бүр хөнгөн шуурхай шийдвэрлэж байна.<br>УУХҮСайдын 2022.03.14-ний өдрийн 1 дүгээр албан даалгавраар өгсөн үүргийн дагуу бүх төрлийн шатахуун, шатдаг хийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2022 оны 3 дугаар сараас зөвхөн https://license.mn/ цахим хуудсаар дамжуулан 100 хувь цахимаар хүлээн авч тухай бүр шуурхай шийдвэрлэж байна. 2022 онд тус цахим | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | системээр дамжуулан нийт 97 тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлтэд шилжүүлсэн. 2022.12.09-ний өдрийн байдлаар бүх төрлийн шатахуун импортлох 17, бөөний худалдаа эрхлэх 23, жижиглэнгийн худалдаа эрхлэх 23, шатдаг хий импортлох 5, бөөний худалдаа эрхлэх 7, АХЦС-аар болон баллоноор жижиглэнгээр худалдаалах 10 тусгай зөвшөөрлийг олгосон байна. | |
| **4.** | **Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.** | | | | | | | |
| 93. | 4.1 | Монгол Улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан эсэх,<br>0- Зохион байгуулсан<br>1- Зохион байгуулаагүй | 0 | 1 | Уул уурхайн салбарын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг УУХҮСайдын 2021.12.24-ний өдрийн А/306 дугаар тушаалаар байгуулан, төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>Уг ажлын хүрээнд "Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хамтын ажиллагаа, боломж, шийдэл" сэдэвт зүүн бүсийн хэлэлцүүлгийг 2022.03.28-29-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн төвд зохион байгуулсан.<br>"Зуун дамжсан уурхайчдын түүчээ" урлагийн их наадмын бүтээл шалгаруулах ажлыг 2022.06.17-18-ны өдөр зохион байгуулсан.<br>"Mining week" салбар сурталчлах арга хэмжээний хүрээнд "Нэн түрүүнд ХАБ-2022" Уул уурхайн салбарын салбар хуралдааныг 2022.09.14-ны өдөр Оюутолгой ХК болон МОШПА ТББ-тай хамтран зохион байгуулсан.<br>"Алтан бамбай-2022" аврах ажиллагааны тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран 2022.09.29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>Уул уурхайн салбарын 100 жилийн ойн хүрээнд 12 дугаар сард зохион байгуулагдах уурхайчдын баярын хурал, хүндэтгэлийн концертын бэлтгэл ажлыг хангасан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Уурхайчдын спортын их наадам-2022” тэмцээнийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан, 2022.11.14-19-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулсан. | |
| **Зорилго 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2021 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.** | | | | | | | | |
| **1. Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | |
| 94. | 1.1. | Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар салбарын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах. | - | Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдсэн байх | 0 | 1 | Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажилласан. Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/01, 2022 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийг шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хууль хоорондын уялдааг сайжруулах зарчимд нийцүүлсэн. Өмнө нь хийгдсэн хөрөнгө оруулалтыг хадгалан үлдээх, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн болон үйл ажиллагааны уялдааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг тусгасан. Хөрөнгө оруулалтын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдад татварын таатай орчин /хөнгөлөлт, урамшуулал/ бүрдүүлэхэд анхаарсан. 2022.09.12-ны өдөр “Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг ХЗДХЯ-нд зохион байгуулж, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулж, “Гадны хөрөнгө оруулагч нарт эрх зүйн тогтолцоо илүү ойлгомжтой болж байгаа”-г хэлэлцүүлэгт оролцогчид онцлон тэмдэглэсэн. Монгол Улсад хийгдэж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 гаруй хувийг уул уурхайн салбар эзэлж байна. | |
| 95. | 1.2. | Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавихад оролцож, үр дүнг тайлагнах. | - | Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо | 5 | 5 | “Монгол орны эрдэс баяжуулалт, боловсруулалтын салбарын техник, технологи, тоног төхөөрөмжийн өнөөгийн түвшин, ашигт малтмалын нөөцийн иж бүрэн ашиглалт, боловсруулалтын судалгаа”-ны зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг боловсруулж, 2022.02.07-нд Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. ТНБДаргын 2022.01.18-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгуулагдсан Тендерийн үнэлгээний хороо УУХҮЯ-ны барилгын засварын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтын /тендерийн/ материалыг хэлэлцсэн. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын шинэчилсэн төсөлтэй танилцан санал өгч, 2022.03.04-нд ГБГ-т хүргүүлсэн. УУХҮЯ-ны ТНБДаргын 2022 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан “УУХҮЯ-ны барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо”-ны хурлаар 2022.04.06-нд Багц-1, Багц-2-ын тендерийн үнэлгээг хийж, саналыг захиалагч талд хүргүүлсэн.<br>- УУХҮЯ-ны ТНБДаргын 2022 оны А/90 дүгээр тушаалаар ”Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх” Дэлхийн банкны төслийн хүрээнд 2022-2023 онд худалдан авах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.<br>-“Монгол орны эрдэс баяжуулалт, боловсруулалтын салбарын техник технологи, тоног төхөөрөмжийн өнөөгийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түвшин, ашигт малтмалын нөөцийн иж бүрэн ашиглалт, боловсруулалтын судалгаа”-ны гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авсан. | |
| 96. | 1.3. | Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах. | - | Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагаа уялдсан байх | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газар нээлттэй, ил тод, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэх зорилтын хүрээнд иргэний нийгэм, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанарыг тэгш хүртээмжтэй болгох, төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтээс гаргаж буй санал, санаачилгыг дэмжих арга замаар тэдний оролцоог нэмэгдүүлэх, хүнд суртал, дарамт чирэгдэл, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээнд шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж бүрэн цахимжуулах зорилгоор дэлхийн 78 улс орнуудын сайн дурын санаачилга болох Нээлттэй Засгийн Түншлэл (www.OpenGovPartnership.org)-д 2013 онд нэгдэн орсон. Засгийн газраас төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, иргэдийн оролцоотой, инновацийг дэмжсэн, эрүүл, аюулгүй нийгмийг бүрдүүлэхэд чиглэсэн байх зарчмыг хэвшүүлэх тодорхой зорилт тавин ажиллаж, энэ хугацаанд “Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлж Засгийн газрын Нээлттэй Засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. | 100 |
| 97. | 1.4. | Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах. | - | Хөрөнгө оруулалт үр өгөөжтэй /эдийн засаг, нийгмийн/ байх | 0 | 1 | Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад дараах бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд:<br>- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Олборлох салбарын засаглалыг сайжруулах төсөл (TA-9752 MON)”, “Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT)”, “Австрали Монголын Эрдэс | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр 2 (AMEP-2)"/-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэсэн.<br>- "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын шинэчилсэн төсөлд саналыг 2022.03.04-нд ГБГ-т хүргүүлсэн.<br>- "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний төсөлд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын чиглэлээр тусгах саналыг нэгтгэн боловсруулж 2022.03.28-ны 01/774 дугаар албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанд танилцуулахтай холбогдуулан тайлбар, тодруулга /2022.04.06/ өгсөн.<br>- Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж ирүүлсэн "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд саналыг ТЗУГ-т хүргүүлсэн.<br>- УУХҮСайдын Канад Улсын "Олон улсын уул уурхайн чуулга уулзалт (PDAC-2022)-д оролцох үеэр хийх уулзалт, ярианы сэдэвт салбарын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар танилцуулга, мэдээллийг /2022.06.08/ хүргүүлсэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийг бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зарчим баримталсан.<br>ХБНГУ-ын геологийн шинжлэх ухаан, байгалийн нөөцийн газар (BGR)-тай | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамтран хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд гэрээ байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын хамтарсан уулзалт, хурлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Монгол Улсад 1990-2021 онд 30.8 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэний 70 гаруй хувь нь уул уурхайн салбарт хийгдсэн.<br>Хөрөнгө оруулалт шаардлагатай ашигт малтмалын ордуудын нөөц, шаардлагатай хөрөнгө оруулалт, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж, төслийн үр ашиг зэрэг техник, эдийн засгийн голлох үзүүлэлтийн талаар мэдээллийг танилцуулсан. | |
| 98. | 1.5. | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, хянан зохицуулах. | - | Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын албаны үйл ажиллагаа уялдсан байх | 0 | 1 | Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын албаны үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:<br>- ОҮИТБС-ын Ажлын албатай хамтран 2022.01.26-нд “Аймаг, нийслэлийн ОҮИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, чадавхижуулах” чиглэлээр цахим зөвлөлгөөнийг зохион байгуулж, холбогдох асуудлаар санал солилцож, зохих шийдвэр гаргуулсан.<br>- ОҮИТБС-ын 2021 оны нэгтгэл тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон Ажлын албаны 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв, санхүүгийн төлөвлөгөөг хянаж, 2022.02.14-нд холбогдох газар /Санхүүгийн хэлтэс/-т хүргүүлсэн.<br>- ОҮИТБС-ын Зүүн бүсийн чуулганы төсвийн тайланг 2022.02.21-ний 03/428 дугаар албан бичгээр Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн.<br>- ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газраас 2022.03.04-нд зохион байгуулсан “Баталгаажуулалт”-ын цахим хуралд оролцож, санал солилцсон. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 15 дугаар буюу 2020 оны нэгтгэл тайлан /уян хатан/ талаар ОҮИТБС-ын Ажлын албаны холбогдох албаны хүмүүстэй 2022.04.05-нд уулзаж, санал солилцсон.<br>- Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн 58 дугаар хуралдааныг 2022.04.28-ны өдөр зохион байгуулсан.<br>- УУХҮСайд, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн дарга, Ажлын албаны холбогдох хүмүүстэй 2022.05.09-нд уулзаж, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл, тулгамдсан зарим асуудлаар санал солилцсон.<br>- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлэх “Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь” төслийн нээлтийн арга хэмжээг 2022.05.19-ний өдөр зохион байгуулсан.<br>- Дэлхийн банкны санхүүжилтээр /буцалтгүй тусламжаар/ 2022-2023 онд хэрэгжүүлэх “Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар Ажлын албаны холбогдох албаны хүмүүстэй /2022.05.23/ санал солилцсон.<br>- Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангийн статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг УУХҮСайдын 2022.05.31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2022.06.08-ны 5852 дугаарт бүртгүүлсэн.<br>- ОҮИТБС-ын Ажлын алба, Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран “Өмнөговь аймаг ба говийн бүсийн уул уурхай, ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалт”-ыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022.06.23-24-ний өдрүүдэд Даланзадгад хотод зохион байгуулсан.<br>-ОҮИТБС-ын Ажлын алба, Сүхбаатар аймгийн ЗДТГ-тай хамтран "Зүүн бүсийн аймгуудын олборлох салбарын ил тод байдлын нэгдсэн чуулга, уулзалтыг 2022.10.27-28-ны өдрүүдэд Баруун-Урт хотод зохион байгуулсан.<br>-Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн 21 дүгээр хуралдаан, АХБ-ын төслийн хаалт, сургалтын удирдамж, хөтөлбөрийг батлуулж, арга хэмжээг /2022.12.20/ зохион байгуулсан.<br>-ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын албаны үйл ажиллагаа зохион байгуулахтай холбогдуулан нийт 22 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагуудад уламжилсан. | |
| 99. | 1.6. | Эрдэс баялгийн салбарын статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах, тайлагнах, удирдлагыг цаг үеийн мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулах. | - | Мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх | 0 | 1 | Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах, тайлагнах, удирдлагыг цаг үеийн мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан. | 100 |
| 100 | 1.7. | Экспортын голлох ашигт малтмалын зах зээлийн судалгаа хийж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон жишиг үнэ тооцох аргачлалыг боловсронгуй болгох. | - | Судалгааны арга аргачлал, санал, зөвлөмж оновчтой байх | 0 | 1 | Экспортын голлох ашигт малтмал болох алт, зэс, жонш, нүүрс, төмөр болон уран, газрын ховор элементийн зах зээлийн судалгаа хийж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон жишиг үнэ тооцох аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажилласан. Үүнд:<br>- Эдийн засгийн форумын хүрээнд тэргүүлэгч орнуудын эрдэс баялгийн салбар дахь бодлого, стратегийн эрдсийн ирээдүйн чиг хандлагын талаар судалгаа, мэдээлэл боловсруулсан.<br>- Эрдэс баялгийн салбарын ерөнхий чиг хандлагын талаарх судалгааны ажлыг боловсруулсан.<br>- Дэлхийн банкны гаргасан судалгаанд үндэслэн түүхийн эдийн зах зээл, хувьсал, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сорилт, бодлогын талаарх хураангүй танилцуулга бэлтгэсэн.<br>- Австрали Улсын ашигт малтмалын нөөц, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын талаарх мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулсан.<br>- БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн индексийн өөрчлөлт ба эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг sxcoal.com сайтнаас авч боловсруулалт хийн удирдлагад танилцуулсан. | |
| **Зорилго 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2022 онд 30 хоногт хүргэнэ.** | | | | | | | | |
| **1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | |
| 101 | 1.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2022 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлыг зохион байгуулах. | - | Арга хэмжээг хуулийн хугацаанд хэрэгжүүлсэн эсэх<br>0-хэрэгжүүлээгүй<br>1-хэрэгжүүлсэн | 0 | 1 | -“Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг түүний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийг УУХҮСайдын 2022.07.01-ний өдрийн 01/1890 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тус яамны эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 2022.11.25-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д байршуулж баталгаажуулсан. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.12.01-ний өдрийн 01/3176 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд УУХҮСайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" УУХҮСайдын 2022.01.18-ны өдрийн 01/131 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн/.<br>УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан 17 зорилт, 72 арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" УУХҮСайдын 2022.01.18-ны өдрийн 01/132 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" УУХҮСайдын 2022.07.01-ний өдрийн 01/1891 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг /нийт 179 шийдвэрийн 269 зүйл, заалтын/ нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын 374 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг сар бүр гарган ХШҮДАГ-т хүргүүлж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус яамны эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2022.10.31-ний өдрийн байдлаар, 2022.11.25-ны | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өдрийн байдлаар нэгтгэн ХШЗДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.12.01-ний өдрийн 01/3176 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдсан УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний төслүүдийн 2021 оны хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /2022.01.18-ны өдрийн 01/131 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./<br>Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.06.16-ны өдрийн 03/1695 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./<br>Засгийн газрын 374 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлж байна. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.12.01-ний өдрийн 01/3176 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд батлагдсан Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн (137 шийдвэрийн 241 зүйл, заалт) хэрэгжилтийн тайланг 2022 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн ХШҮДАГ-т 2022.06.22-ний өдөр хүргүүлсэн.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан Улсын Их Хурлын тогтоолын нийт 4 шийдвэрийн 6 зүйл, заалтын биелэлтийг нэгтгэж 2022.11.09-нд ХШҮДАГ-т хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын 2021 онд баталсан нийт 412 тушаалын биелэлтийн хэрэгжилтийг нэгтгэж ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>Гадаадын зээл тусламжаар хэрэгждэг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг УУХҮСайдын 2022.02.21-ний өдрийн 01/437 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн./<br>Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дах хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийг ТНБДаргын 2021.11.22-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024), УУХҮЯ-ны стратеги төлөвлөгөө (2020-2024) зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн газруудын саналыг авч нэгтгэн боловсруулж, байгууллагын удирдлагын зөвлөлийн 2022.01.05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ТНБДаргаар | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулан УУХҮСайдаар хянуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. УУХҮЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийг Батлагдсан төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолын дагуу “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу УУХҮЯ-ны архивт хүлээлгэн өгсөн.<br>УУХҮЯ-ны 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэж ХШҮДАГ-т 2022.01.04-ний өдөр хүргүүлсэн. Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу УУХҮЯ-ны 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг УУХҮЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. /УУХҮЯ-ны 2021 оны нэгдсэн тайланг УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/823 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн./ | |
| 102 | 1.2 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх. | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих шийдвэрлэлтийн %<br>0-нэмэгдээгүй<br>1-нэмэгдсэн | 2021 онд 99 % | 99% | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, АМГТГ болон ҮГА-д иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг 2021 оны жилийн эцсийн байдлаар 2022.01.10-ны 03/65, 2022 оны I улирлын байдлаар 2022.04.07-ны 03/922 тоот албан бичгээр тус тус гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллаа.Тус яаманд 2022 онд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс бичгээр 208 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна .Үүнд: ТЗУГ-134, ГБГ-20, УУБГ-16, ХҮБГ-3, ГТБГ-14, СХОГ-1, ХШҮДАГ-12<br>а/ Нийт 208 өргөдөл гомдлоос:<br>-шийдвэрлэсэн-200<br>-хяналтанд байгаа- 8<br>б/ Өргөдөл-130 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Гомдол-45<br>Санал-3<br>Хүсэлт-30<br>Шийдвэрлэлт 96,1 %- тай байна. | |
| 103 | 1.3 | УУХҮЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж тайлагнах. | - | Салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх<br>0-зохион байгуулсан<br>1-зохион байгуулаагүй | 2021 онд 95% | 96% | УУХҮЯ-ны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталсан.<br>Төлөвлөгөөний дагуу Салбар зөвлөлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2022.12.20-ны өдрийн байдлаар салбар зөвлөл нь 3 гишүүнтэй байна.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар салбар зөвлөл нь: -2021 оны Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, яамны төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан бусад холбогдох материалыг Төрийн албаны зөвлөлд 2022.01.05-ны өдрийн 22/01 дугаар албан бичгээр хугацаанд нь хүргүүлээд байна.<br>-Төрийн албаны зөвлөлөөс нийт 18 бичиг ирүүлснээс 8 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. Нийт 3 удаагийн хуралдааныг зохион байгуулж холбогдох шийдвэр гарч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>-Мөн ТАЗ-өөс ирүүлсэн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг 13 хавсралтаар нэгтгэн хүргүүлсэн.<br>-УУХҮЯ-ны ТЗУГ-ын дарга, ҮГА-ны ГСХ-ийн дарга ТЗУХ-ийн Хуулийн мэргэжилтэн, Ашигт малтмал, газрын тосны газрын 5 мэргэжилтний сул орон тоог нөхөх тухай хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж Тусгай шалгалтыг зохин байгуулсан бөгөөд энэ тухай тайланг ТАЗ-д хугацаанд нь хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн зохион байгуулдаг 7:4:10 сургалтад нийт 28 удаагийн сургалтад цахимаар оролцсон. | 100 |
| 104 | 1.4 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг | - | Авлигтай тэмцэх үйл ажиллагааны | 2021 онд нээлттэй | 61% | УУХҮЯ-ны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022.03.11-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, тайлагнах. | | хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан эсэх 0-үгүй 1-тийм | байдлын үнэлгээ 60 % | | Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж байна. Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу яамны ажиллагсдын болон харьяа үйлдвэр компаниудын зарим удирдах ажилтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан авч АТГ-т хүргүүлсэн. /2022.03.01, 03/522/ Хугацаа хожимдуулсан албан хаагч байхгүй болно. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 86 албан хаагч ХАСХОМ-ын мэдүүлэг өгсөн. Яамны 17 албан хаагчийн ХАСУМ-ын мэдүүлэгийг хянуулсан. Авлигатай тэмцэх газрын Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Ганхуягтай хамтран 2022 онд Авлигын эсрэг хамтдаа сэдэвт аяны хүрээнд яамны сурталчилгааны самбарыг шинэчлэн яамны вэб сайтанд мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг сургалтад 6 албан хаагчийг сургалтад хамруулаад байна. Тайлант оны хугацаан Авлигатай тэмцэх газраас нийт 30 албан бичиг хариутай 4 албан бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | |
| 105 | 1.5 | Салбарын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулах, салбарын мэргэжлийн сургалтын байгууллага их, дээд сургууль, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран мэдлэг, ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах. | Сайдын багцийн холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс | Сургалт зохион байгуулсан эсэх 0-үгүй 1-тийм | 2021 онд 10 төрлийн сургалтанд нийт 72 /давхардсан тоогоор/ албан хаагчийг сургалтанд хамруулсан. | Сургалтийн төрлийг нэмэгдүүлж 10-аас дээш. Албан хаагчидыг хамруулах байдал 75 | УУХҮЯ-ны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилгодсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 9, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 9, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугмаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 100 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | |
| 106 | 1.6 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах. | Сайдын багцийн холбогдох зардал | Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх | Бичиг хэргийн шийдвэрлэлт 91 % | 92% | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2022.12.13-ны байдлаар нийт 6362 албан бичиг ирснийг хүлээн авч бүртгэлд оруулсан ба үүнээс хариутай бичиг 2674, хариугүй бичиг 3688 ирсэн байна. Хариутай 2674 албан бичгээс 2350 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба 153 бичиг хяналтын шатанд явж байгаа ба шийдвэрлээгүй 168 албан бичиг байна.<br>УУХҮЯ-наас 2022.12.13-ны байдлаар нийт 3266 албан бичгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яамд болон бусад аж ахуйн нэгж , хувь хүмүүст явуулсан болно.<br>Яамны хэмжээнд нийт 204 өргөдөл болон гомдол ирснийг бүртгэн авч, мэдээ тайланг өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн сар бүр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт явуулсан.<br>Эрх зүйн акт болох Ерөнхийлөгчийн зарлиг-1, Ерөнхий сайдын захирамж-40, Ерөнхий сайдын албан даалгавар-5, Засгийн газрын тогтоол-72, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-127 ирсэн ба эдгээрийг хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, шийдвэрийг хангуулан ажилласан.<br>Ирсэн бичгийн 63820 хуудас, явсан бичгийн 16593 хуудас, өргөдөл гомдлын 1103 нийт 81516 хуудас материалыг сканнердаж PDF файл болгон цахим архив үүсгэж ажилласан.<br>Ирсэн бичгийн бүртгэлийн 17, явуулсан баримт бичгийн 5, эрх зүйн акт болон өргөдөл гомдлын нийт 24 бүртгэлийн дэвтрийг хөтлөн ажилласан.<br>Засгийн газрын хэвлэх үйлдвэрээр яамны хэвлэмэл хуудсыг, Хараагүйчүүдийн хэвлэх үйлдвэрээр дугтуйнуудыг хийлгүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байгаа ба Түгээмэл шуудангаар албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.** | **Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| 107 | 2.1 | УУХҮСайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох. | - | Төлөөлсөн эсэх<br>0– төлөөлөөгүй<br>1-төлөөлсөн | 2021 онд 34 | 34-өөс бага | 1.“Хил хязгааргүй алхам” ТББ,<br>2.Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК,<br>3. “Даблью Ти Эл Ди” ХХК,<br>4.“Шунхлай энержи” ХХК-ийн нэхэмжлэлтэй Арбитрын хэрэг,<br>5. Сонор трейд ХХК,<br>6.Лучеро ХХК<br>7.Дөрвөн талст эрдэнэ ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдаанд олгосон итгэмжлэлийн хүрээнд тухай бүр оролцсон. | 100 |
| 108 | 2.2 | Салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан төсөлд санал зөвлөмж өгөх, хуульд нийцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх. | - | Боловсруулж, хүргүүлсэн эсэх<br>0– үгүй<br>1-тийм | 0 | 1 | 1.Геологи, уул уурхайн салбарын эрх зүйн орчинтой холбогдуулж, УУХҮСайдын 2021.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар батлагдсан “МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын 12.8-д заасан Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах, хүнээс хамааралгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээний хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох нөхцөл боломжийг судлах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллан, УУХҮСайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5821 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>2.Геологийн бодлогын газраас боловсруулсан Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаж, УУХҮСайдын 2022.05.02-ны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрийн А/87 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5828 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>3. СХОГ-аас боловсруулан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангийн дараах захиргааны статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг УУХҮСайдын 2022.05.31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5852 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>4.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны дэд ажлын хэсэгт ажиллан 2022.06.15-ны өдөр Үйлдвэржилтийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж Улсын Их Хурлын 2022.06.16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Тус хууль нь 2022.07.05-ны өдөр батлагдаж, 2022.08.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.<br>5.Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УУХҮЯ, АМГТГ болон ҮГА нартай хамтарсан уулзалт хийж, санал солилцож, уг хуулийн төсөлд саналыг хүргүүлэв.<br>6.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаран улсын уул уурхайтай холбоотой хууль тогтоомжийг судлан Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой санал, үзэл санааг сонсох, нэгдсэн нэг байр сууринд хүрэх зорилт тавин ажилласан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, тайланг хийгээд байна. Үүнд: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно. Мөн үзэл баримталлын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас санал авахаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.<br>7.Хүнд үйлдвэрийн газраас боловсруулан УУХҮС, БСШС, ХХААХҮС нартай хамтран баталсан "Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох" журмыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5553 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>8.Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ажлын хэсгийг УУХҮСайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс санал авахаар ГТБГ-ын Даргын 2021.09.09-ний өдрийн 08/2198 дугаар албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг судалгааны тайлангуудыг тус тус боловсруулсан. Тус хуулийн төслийг 2022 оны УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. УУХҮСайдын 2022 оны А/44 дүгээр тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч, саналын товъёог нэгтгэсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-ын чуулганаар хэлэлцэн дэмжигдэж, батлагдаад байна.<br>9.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.11.02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 8 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар зүйлд заасны дагуу яамны цахим хуудас, “Нээлттэй нийгэм форум” болон “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга” төслийн цахим хуудсанд тус тус байршуулж санал авч, хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2020.10.06-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хуулийн төсөл, дагалдах хуулийн болон дүрэм, журам боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөх 2020 оны 12 дугаар сараас ажиллаж, өмнө боловсруулсан хуулийн төсөлд тулгуурлаж шинэчилсэн хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан. Ажлын хэсгийн гишүүд нь хуулийн төслийн бичвэрийг эцэслэж, Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулганд багтаан өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.<br>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд шилжүүлэн хүргүүлсэн болно.<br>10.ГТБГ-аас боловсруулсан Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага болон тайлангийн хүснэгтийн загварын төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаж, УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 6017 дугаарт бүртгүүлэв.<br>11.ГТБГ-аас боловсруулсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн төслийг хуулийн хүрээнд хянаж, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 109 | 2.3 | | | | | | засч сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/288 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 6018 дугаарт бүртгүүлэв.<br>12.ХҮБГ-аас боловсруулсан Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮСайдын 2022.09.22-ны өдрийн А/245 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 5959 дугаарт бүртгүүлэв.<br>13.ХҮБГ-аас боловсруулсан Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журмын төсөл, Технологийн түвшний үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалын төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮСайдын 2022.06.22-ны өдрийн А/135/А/200 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 5874 дугаарт бүртгүүлсэн. | |
| 109 | 2.3 | Салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын мэдээллийн сан бүрдүүлэх, | - | Мэдээллийн сан бүрдүүлэх эсэх | 0 | 1 | Нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг лавлагаа мэдээллээр тухай бүр хангаж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэд, аж ахуйн нэгж байгууллагад лавлагаа мэдээллээр үйлчлэх. | | 0– үгүй<br>1-тийм | | | үйлчилсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэсэн. | |
| **3.** | **Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын багцын төсвийн гүйцэтгэл 2021 онд 91,2 хувь байсныг 2022 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 110 | 3.1. | УУХҮСайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2021 оны батлагдсан төсвийн хуваарь, 2022 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын санал, төсвийн төслийг боловсруулж батлуулах. | Сайдын багцийн холбогдох зардал | Шийдвэрлүүлсэн эсэх:<br>0-шийдвэрлүүлээгүй,<br>1-шийдвэрлүүлсэн | 0 | 1 | Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон танилцуулгатай танилцан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл болон экспортын төсөөлөл, бүтээгдэхүүний үнэ, 2022 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023-2025 оны төсөөллийг холбогдох тайлбар, танилцуулгатайгаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022.04.01-ний өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 03/851 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Улсын Их хурлын 2022.05.27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмблэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу боловсруулан 2022.05.31-ний өдрийн 01/1557 дугаар албан бичгээр Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны Хөрөнгө оруулалтын цахим системд 2023 оны шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний мэдээллийг хуулийн хугацаанд илгээж, холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан УУХҮСайдын 2023 оны төсвийн хязгаарын санал, 2024-2025 оны төсөөллийг боловсруулан “2023 оны төсвийн хязгаарын санал, 2024-2025 оны төсөөлөл хүргүүлэх тухай” 01/1605 тоот албан бичгийг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн холбогдох тайлбар, үндэслэлээр хангаж ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022.06.29-ний өдрийн 258 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн хязгаарыг баталсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2023 оны төсвийн хязгаарыг төсөвт төвлөрүүлэх орлогыг 415.6 тэрбум төгрөгөөр, зарлагыг 40.9 тэрбум төгрөгөөр тус тус баталсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмблэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу боловсруулан төсвийн төслийн саналд тусган УУХҮСайдын 2022.08.15-ны өдрийн 01/2208 дугаар албан бичгээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. 2023 оны төсвийн төслийн саналыг Сангийн яамнаас боловсруулан хүргүүлэхдээ төрийн хэмнэлтийн хүрээнд 2023 онд шилжих төслүүдэд хөрөнгө оруулалтын зардлыг тусгахаар төсөвлөж шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт төсөв тусгаагүй болно. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсөөллийг боловсруулан 2022.08.15-ны өдрийн 01/2213 дугаар албан бичгээр Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны Төсвийн бодлогын газартай холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан. Мөн 2021 онд төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсөөллийн санал хүргүүлэх тухай УУХҮСайдын 2022.08.15-ны өдрийн 01/2212 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хүргүүлсэн.<br>2023 оны төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 488.3 тэрбум төгрөгөөр, зарлагыг 39.6 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Үүнээс урсгал зардалд 16.1 тэрбум төгрөг, геологи хайгуул судалгааны зардал 23.5 тэрбум төгрөг батлагдсан байна.<br>Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч-ын "Уул уурхайн олборлолт" хөтөлбөрийн хүрэх үзүүлэлтийн 2021 оны биелэлтийг нэгтгэн "Хөтөлбөрийн биелэлт хүргүүлэх тухай" ТНБДаргын 2022.03.17-ны өдрийн 03/684 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.<br>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Уул уурхай, хүнд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлдвэрийн сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч-ын “Уул уурхайн олборлолт” хөтөлбөрийн хүрэх үзүүлэлтийн 2022 оны эхний хагас жилийн биелэлтийг нэгтгэн “Хөтөлбөрийн биелэлт хүргүүлэх тухай” ТНБДаргын 2022.07.21-ний өдрийн 04/2042 дугаар албан бичгийг Сангийн яаманд хүргүүлж биелэлтийг шилэн дансанд байршуулан ил тод байдлыг хانган ажилласан. | |
| 111 | 3.2. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллах. | УУХҮСайдын багц 41,579.1 сая.төгрөг | Хуулийн хугацаанд зохион байгуулж ил тод байдлыг хангах<br>0-Хангаагүй<br>1-Хангасан | 0 | **1** | 1.Захиалагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг УУХҮСайдын 2021.11.24-ний өдрийн А/283 дугаар тушаалаар батлуулсан. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдаж төсөвт тодотгол хийсэнтэй холбоотойгоор 2022 оны А/31, А/104 дүгээр тушаалуудаар зохих өөрчлөлтүүдийг оруулан батлуулсан.<br>2.Уул уурхайн салбарын төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахимаар хянан батлах ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хариуцан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/31, А/104 дүгээр тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албаны 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.06.03-ны өдрийн А/127 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт оруулан батлуулсан.<br>3. Захиалагчийн болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан даруйд нь болон өөрчлөлт орсон тухай бүр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -д оруулан, Сангийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | яамаар хянуулан батлуулж ажилласан. 2022 онд Сангийн яаманд нийт 6 удаагийн өөрчлөлтийн хүсэлтийг гарган шийдвэрлүүлж ажилласан.<br>4. Захиалагчид шаардлагатай худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 2022 онд нийт 5 үнэлгээний хороог Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан. (2022 оны А/02, А/08)<br>Үнэлгээний хороо байгуулагдсан тушаалыг үндэслэн төрийн худалдан авах ажиллагааны системд шаардлагатай мэдээллийг оруулах, үнэлгээний хороодын нарийн бичгийн дарга нартай байнга холбоотой ажиллах, хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажилласан.<br>5. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификат олгох сургалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдыг хамруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон, нийт 35 албан хаагчийг худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамруулах боломжтой гэж үзсэн. Батлагдсан төсөвт багтаан нийт 25 албан хаагчийг сургалтад хамруулснаас 10 албан хаагч сертификат авсан.<br>6.2022 оны 6 дугаар сарын байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нийт 26 албан хаагч худалдан авах ажиллагааны хүчинтэй А3 сертификаттай байгаа бөгөөд эдгээрээс 11 албан хаагчийн хүчинтэй хугацаа 2023 оны I улиралд дуусахаар байна. Яамны нийт 35 албан хаагчийг худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамруулах боломжтой байна.<br>Худалдан авах ажиллагааг хариуцсан мэргэжилтэнд зөвлөмж өгч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2022.01.14-ний өдрийн 03/99 дугаар албан бичгээр, УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний аж ахуйн нэгж байгууллагуудын 2021 онд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний тайланг нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2022.02.09-ний 01/288 дугаар албан бичгээр хүргүүлж, дотоод худалдан авалтын нэгдсэн тайланд нэгтгүүлэх чиглэлийг өгч мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан. | |
| 112 | 3.3 | Салбарын сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын төсвийн багцын зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хуваарийн дагуу санхүүжүүлж гүйлгээг хянан баталгаажуулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох газарт хүргүүлэх. | Зарлага 48,193.6 сая төгрөг | Бэлтгэл хангагдсан эсэх<br>0-хангагдаагүй<br>1-хангагдсан | 0 | 1 | УУХҮСайдын /ТЕЗ/-ын батлагдсан төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын хуваарийн саналыг боловсруулж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхэд харьяа байгууллагын холбогдох албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдамжаар хангаж, төсвийн хуваарийн саналыг нэгтгэн боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. Сангийн сайдын 2022.01.04-ний өдрийн 4-1/26 дугаар албан бичгээр ирүүлсэн Сангийн сайдын 2021.12.27-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьтай танилцан батлагдсан хуваарийг харъяа байгууллагуудад 2022.01.21-ний өдрийн 03/157 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны төсвийн хуваарийг Сангийн яамнаас батлахдаа зарим зардлуудыг 12 сард санхүүжүүлэхээр баталсан нь 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зарим зардлын хуваарьт өөрчлөлт оруулах нөхцөл байдлыг бий болгосон. Санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг Сангийн яаманд тухай бүрт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлж хуваарьт холбогдох өөрчлөлтийг оруулсан. УУХҮЯамны урсгал зардлаас 771.5 сая төгрөг, АМГТГ-ын урсгал зардлаас 1,573.8 сая төгрөг, ҮГА-ны урсгал зардлаас 176.5 сая төгрөг, Геологи, хайгуул, судалгааны ажлын зардлаас 21.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус нээлгэж, хуваарьт холбогдох өөрчлөлтийг оруулж санхүүжилтийг олгосон байна.<br>- УУХҮСайдын багцын 2022 оны төсвийн зардалыг 48.2 тэрбум төгрөгөөр баталсныг 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 7.0 тэрбум төгрөгөөр бууруулж 41.2 тэрбум төгрөг болгон батлаад байна. Төсвийн тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор 2022 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарим зардлуудыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай болсон тул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны болон харьяа байгууллагуудын урсгал зардалд зохицуулалт хийх зайлшгүй шаардлага гарч хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Төсөвт тодотгол, зохицуулалт хийгдэж хуваарьт өөрчлөлт орсонтой холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардалд 2022 оны байдлаар нийт 768.7 сая төгрөгийн шаардлагатай зохицуулалтуудыг хийлгэсэн байна.<br>УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад мэргэжил арга, зүйн зөвлөгөөгөөр хангаж шаардлагатай зааварчилгааг цаг тухай бүрт өгч хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.<br>Төлбөр тооцоог төрийн сангаар гүйцэтгэхдээ 2022 оны батлагдсан зардлын хүрээнд Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах заавар, журмын дагуу төлбөр тооцоог хийж байгаа эсэхэд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сар бүр хяналт тавьж төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийг зөвлөмжөөр хангаж ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн сангийн нэгжээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба төлбөр тооцоогоо хийж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын нийт 19 данс төрийн санд бүртгэлтэй байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хөврүүлэлтийн 100900018701 дансаар яам болон харъяа байгууллагуудын гадаад төлбөр тооцооны хөврүүлэлтийг хийж сургалтын төлбөр болон гишүүнчлэлийн хураамжийн төлбөрийг шилжүүлж гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай хийж гүйцэтгээд байна.<br>- Сангийн яамнаас 2022 онд Эрхийн бүртгэлийн сан системийг бүрэн нэвтрүүлж төлбөр тооцоог цахимаар баталгаажуулж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, хөрөнгө оруулалтын цахим системээр хийгдэж буй төлбөр тооцоог цахимаар хийх бэлтгэл ажлыг ханган харъяа байгууллагуудад цахим төлбөр тооцооны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч 6 дугаар сараас цалингийн гүйлгээг 10 дугаар сараас хөрөнгө оруулалтын санхүүжилтийг цахимаар бүрэн гүйцэтгэдэг болсон.<br>Сангийн яамны Валютын төлбөр тооцооны нэгдсэн системээр дамжуулан Төрийн сангийн гадаад төлбөр тооцоог гадаад гүйлгээний программ ашиглан Төрийн банкаар дамжуулан гүйцэтгэж байгаа ба төрийн сангийн мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч, гадаад сургалтын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавьж, зөвлөмжөөр ханган ажилласан.<br>УУХҮСайдын багцын 2021 оны 12 сар, 2022 оны эхний 11 сарын гүйцэтгэлийн мэдээг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгтгэн боловсруулах, сар бүр хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлэхэд зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажилласан. | |
| 113 | 3.4 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайланг хуулийн хугацаанд хянан хүлээн авах, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулах зөвлөмжөөр хангах, УУХҮСайдын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж, аудит хийлгэх ажлыг зохион байгуулах. | - | Төсвийн тухай хуулийн 8.9.1, НББ-ийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйл | Тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн байх. Үнэн зөв байх | Тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ. | 1.Сайдын багцын харьяа байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2022.01.25-ны өдрийн дотор, аудитлагдсан тайланг 2022.03.25-ны өдрийн дотор хуулийн хугацаанд шалган хүлээн авах, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллуулах чиглэлээр Сайдын багцын харьяа байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудад албан тоот хүргүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд нийт 25 байгууллагын баталгаажсан тайланг хүлээн авч нэгтгэхэд зөвлөмжөөр хангаж ажилласан.<br>2.Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран Сайдын багцын харьяа байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч нартай уулзах уулзалтыг зохион байгуулсан. Энэ уулзалтаар 2021 оны нэгдсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтэд анхаарч ажиллах болон Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хангаг ажиллах талаар мэдээлэл өгч мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.<br>УУХҮСайдаас 2021 оны жилийн эцсийн тайланд аудит хийлгүүлэхэр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн албан тоотын дагуу аудит хийхэд шаардлагатай тайлбар, үндэслэлээр ханган, дүгнэлт гаргуулсан. Аудитлагдсан тайланг Засгийн газрын нэгдсэн тайланд нэгтгүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөмж, тайлбар, үндэслэлээр ханган ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | 3.5 | УУХҮСайдын багцын хөрөнгө оруулалт, улсын төсвөөр хийгдэх геологи судалгааны ажлын санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж удирдлагад танилцуулан баталгаажуулж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулах ажлыг зөвлөмжөөр хангаж, удирдан зохион байгуулах. | Геологи-32,953.5 сая төгрөг Хөрөнгө оруулалт-2,508.3 сая төгрөг | Тайланг хугацаанд нь гаргаж, дүгнүүлсэн эсэх 0 - зөрчилтэй, 1 - зөрчилгүй | 0 | 1 | 1.УУХҮСайдын багцын хөрөнгө оруулалтын ажлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган удирдлагад танилцуулж баталгаажуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын нэгтгэсэн тайланд нэгтгэхэд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.<br>2.УУХҮСайдын багцад 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.5 тэрбум төгрөг батлагдсан ба 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Хөрөнгө оруулалтын зардлыг 1.1 тэрбум төгрөгөөр бууруулж 1.4 тэрбум төгрөг болгон батлаад байна. Уг хөрөнгө оруулалтаар Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийн бүтээн байгуулалтын ажилд Төрийн худалдан авах ажиллагааны газраас 5 багц тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. 2022.12.15-ны байдлаар 835,4 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан. Хүлээгдэж байгаа гүйцэтгэл 488,1 сая төгрөг, 2022 онд Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бүрэн санхүүжихээр байна.<br>2022 оны Төсвийн тухай хуулиар геологи, хайгуул, судалгааны ажлын зардалд 32.9 тэрбум төгрөг батлагдсан ба 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар геологи, хайгуул, судалгааны ажлын зардлыг 5.2 тэрбум төгрөгөөр бууруулж 27.7 тэрбум төгрөг болгон батлаад байна. УУХҮСайдын 2022.01.14-ний өдрийн А/06 тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, тайлагнах ажлыг Үндэсний геологийн албанд шилжүүлсэн.<br>Геологи судалгааны ажлын гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, тайлагнах ажлыг Үндэсний геологийн албанд шилжүүлсэнтэй холбоотойгоор Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газар, Төрийн сангийн газарт албан бичиг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
